



The best
**Corporate
Banking**
in Mongolia

ШИЛДЭГ САНХҮҮЧДИЙН ШИРЭЭНИЙ НОМ 2024



АГУУЛГА

БҮЛЭГ 1.

ОЛОН УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

- Дэлхийн эдийн засгийн төлөв
- АНУ-ын эдийн засаг
- БНХАУ-ын эдийн засаг
- ОХУ-ын эдийн засаг
- Түүхий эдийн үнийн хүлээлт

БҮЛЭГ 2.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

- 2023 оны товч хураангуй
- Төсвийн эргэн тойронд
- Цалин, өрхийн бодит орлого, зардал
- Гадаад худалдаа
- Төлбөрийн тэнцэл, валютын нөөц, ханш
- Банкны салбарын тойм
- Инфляц, мөнгөний бодлого
- Эдийн засгийн өсөлт

БҮЛЭГ 3.

ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРУУД

- Уул уурхай, тээвэр
- Худалдаа, үйлчилгээ
- Үйлдвэрлэл

БҮЛЭГ 4.

ЭДИЙН ЗАСГИЙН ИРЭЭДҮЙН ТААМАГЛАЛ

- Эдийн засгийн таамаглал
- Инфляцын таамаглал

The image features a large, stylized number '1' in a light blue color, positioned centrally above the main text. The background is white, adorned with abstract geometric shapes in various shades of blue and yellow. On the left side, there is a dark blue shape with a yellow triangle pointing towards it. Below this, a light blue shape with a yellow triangle is visible. In the bottom right corner, a large, dark blue shape with a yellow triangle is present. A thin yellow line curves around the bottom right shape. The overall design is modern and minimalist.


1

ОЛОН УЛСАД
ЭДИЙН
ЗАСГИЙН
НӨХЦӨЛ
БАЙДАЛ

Дэлхий дахиныг хамарсан цар тахал, геополитикийн тогтворгүй байдал, тэдгээрээс үүдэлтэй тээвэр, логиستيкийн саатал, үнийн өсөлт болон мөнгөний хатуу бодлогын нөлөө 2023 оны турш үргэлжилсэн ч дэлхийн эдийн засаг 3.3%-р өссөн. Харин 2024 он гарснаас хойш инфляц улс орнуудад тасралтгүй буурч төв банкнуудын зорилтот түвшинд ойртсоноор мөнгөний зөөлөн бодлого хэрэгжүүлэх орон зай гарч, ихэнх төв банкнууд бодлогын хүүгээ бууруулж эхэлж байна. Тухайлбал, Холбооны Нөөцийн Сан энэ оны 9 сарын мөнгөний бодлогын хорооны хурлаар бодлогын хүүгээ 50 нэгжээр бууруулж 4.875%-д хүргэсэн нь цар тахлын эхэн үеэс хойш анх удаа хүүг бууруулсан шийдвэр боллоо. Харин Европын холбоо бодлогын хүүгээ 0.25 нэгжээр бууруулж 3.5%-д хүргэсэн нь бүс нутагт инфляц тогтворжсонтой холбоотой байна.

Ийнхүү улсуудын бодлогын хүүний бууралт нь дэлхийн эдийн засгийн идэвхжилийг голлон дэмжиж дэлхийн нийтийн чиг хандлага байгаль орчинд ээлтэй ногоон үйлдвэрлэл болон техник технологийн чиглэлд түлхүү анхаарч эхэлж байна. Цаашлаад олон улсын нийт үйлдвэрлэл, худалдааны өсөлт сүүлийн 10 жилд хамгийн бага хэмжээнд байгаа бөгөөд энэ нь дундаж болон доогуур орлоготой улсуудын амьжиргааны түвшин өсөн нэмэгдэхгүй, удааширч байгаагаас голлон шалтгаалж байна. Гэсэн хэдий ч дэлхийн эдийн засаг хэдэн жил үргэлжилсэн сөрөг шокийн дараа тогтвортой төлөвт шилжиж байгааг олон улсын судалгаануудад онцолжээ.

ОУВС-н эдийн засгийн өсөлтийн төсөөлөл




Эх сурвалж: Олон улсын валютын сан, 2024 оны 4-р сар

Эдийн засгийн идэвхжил хүлээлтээс өндөр байгаа тул олон улсын байгууллагууд ч дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллөө сайжруулсаар байна. Тухайлбал, Олон улсын валютын сан энэ оны 4 сард гаргасан тайландаа 2024 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 3.2% болгон өмнөх төсөөллөөс 0.1 нэгж хувиар нэмэгдүүлсэн бол Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага (ЭЗХАХБ)-с 5 сарын тайландаа 3.1% болгон өмнөх төсөөллөөс 0.2 нэгж хувиар тус тус нэмэгдүүллээ. Хэдийгээр геополитикийн тогтворгүй байдал, үнийн өсөлт, мөнгөний бодлогын төлөв зэрэг хүчин зүйлс эдийн засгийн идэвхжилийг хязгаарлаж байгаа ч дэлхийн эдийн засгийн өсөлт 2024-2025 онд тогтвортой байна гэж олон улсын байгууллагууд үзэж байна. Тухайлбал ОУВС-ийн төсөөллөөр дэлхийн эдийн засгийн өсөлт 2024 онд 3.2%, 2025 онд 3.3%-д хүрэх хүлээлттэй байна. Үүнийг улс орнуудын хөгжлийн ангиллаар задлан харвал, өндөр хөгжилтэй орнуудын эдийн засгийн өсөлт 1.8%, хөгжиж буй эдийн засагтай орнуудын өсөлт 4.3% байна. Өндөр хөгжилтэй орнуудын хөдөлмөрийн зах зээл агшиж, дотоод эрэлт тогтворжиж, мөн төсвийн бодлого чангарч байгаагаас үүдэн эдийн засгийн хувьд харьцангуй тогтвортой өсөлт үзүүлэх төлөвтэй байгаа бол хөгжиж буй орнуудын хувьд ирэх онд дотоод хэрэглээ болон экспортын хэмжээ өснө гэсэн таамаглалын хүрээнд эдийн засгийн өсөлтийг өндрөөр төсөөлжээ.

АНУ-ЫН ЭДИЙН ЗАСАГ

АНУ-ын эдийн засаг 2024 оны 2-р улиралд 3%-р өсөж идэвхжилээ. Эдийн засгийнхаа 68%-ийг бүрдүүлдэг хувийн хэрэглээ нь 2.9%-р өсөж төсөөлж байсан 2.3%-с өндөр гарсан нь эдийн засгийн өсөлтийг голлон дэмжсэн байна.


АНУ-ын эдийн засгийн өсөлт



Эх Сурвалж: Federal Reserve Economic Data, OYBC

Цаашлаад хөрөнгө оруулалт 7.5%-р өссөн бол жижиглэн худалдааны борлуулалт 2.4%-р мөн өсжээ. Санхүүгийн үйлчилгээ болон эрүүл мэндийн салбарын өсөлт тус бүр 7.9% ба 5.5% байна. Харин ОУВС-ийн төсөөллөөр АНУ-ын эдийн засгийн өсөлт 2024 онд 2.6%, 2025 онд 1.9% байх хүлээлттэй байна.

АНУ-ын бодлогын хүү, инфляц



Эх Сурвалж: Federal Reserve Economic Data

АНУ-ын инфляц 2022 оны 6-р сард 9%-д хүрсэн нь 1980-аад оноос хойших хамгийн өндөр инфляцын түвшин байв. Үүнтэй холбоотойгоор ХНС бодлогын хүүгээ сүүлийн 16 сарын турш 11 удаа өсгөж 0.125%-с 5.375% болгосон нь 2001 оноос хойших хамгийн өндөр үзүүлэлт болж байлаа. Харин удаан үргэлжилсэн мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр 2024 он гарснаас хойш инфляц тасралтгүй буурч 8-р сард 2.5% гарсан нь ХНС-г бодлогын хүүгээ бууруулах нэг гол шалтгаан боллоо (Trading Economics, 2024).

Цаашлаад дэлхийн хамгийн том гүрний ерөнхийлөгчийн сонгууль энэ онд тохиож буй юм. Улс төрийн тогтвортой байдал, бодлогын арга хэрэгслүүд нь эдийн засгийн нөхцөл байдалд чухлаар тооцогдох тул аль намаас, ямар нэр дэвшигч сонгуульд ялж ямар бодлого баримтлах нь макро эдийн засгийн ирээдүйн хүлээлтэд чухал юм. АНУ-ын ерөнхийлөгчид өрсөлдөж байгаа Дональд Трамп энэ удаагийн сонгуульд ялбал АНУ-д импортолж буй бүх бараа бүтээгдэхүүнд 10 хувийн импортын татвар, харин Хятад улсаас импортлох бүх бараанд 60 хувийн татвар ногдуулна гэж мэдэгдсэн. (American Action Forum, 2024).

Хэрвээ Хятадад ногдуулах тариф хэрэгжвэл АНУ-ын хэрэглэгчид нэмэлтээр жилд 300-500 тэрбум ам.долларын зардал гаргах бөгөөд энэ нь нэг өрхөд дунджаар 1,950 ам.долларын зардал ногдох тооцоолол гарсан байна. Эдгээр бодлогын өөрчлөлтөөс шалтгаалж инфляц дахин өсөх магадлалтай болохыг шинжээчид анхааруулж байна (American Action Forum, 2024).

БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГ

Манай улс нь түүхий эдийн экспортоос өндөр хамааралтай, тиймдээ ч нийт уул уурхайн бүтээгдэхүүний экспортын 95%-ийг Хятад улс руу гаргадаг тул хөрш орны эдийн засгийн нөхцөл байдал, цаашдын төлөв чухал нөлөөтэй билээ.

БНХАУ-ын эдийн засаг сүүлийн жилүүдэд удааширч байгаа нь хэд хэдэн үндсэн шалтгаантай. Тухайлбал, Хятад улс 2020 оноос эхлэн “ТЭГ-КОВИД” бодлого хэрэгжүүлж хилээ хаасан нь үйлдвэрлэгч орны экспортын орлогод сөргөөр нөлөөлсөн. Цаашлаад томоохон барилгын компаниудын өр хэт нэмэгдэж, төлбөрийн дарамтад орж дампуурлаа зарласнаар үл хөдлөх хөрөнгийн салбар одоог хүртэл уналттай байна. Мөн барууны орнуудтай харилцаа хурцдахын хэрээр Хятадын үйлдвэрлэдэг цахилгаан авто машин болон бусад үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнд ногдох татварыг нэмэгдүүлж өсөлтөд сөргөөр нөлөөлж байна.

БНХАУ Эдийн засгийн өсөлт, инфляц



Эх Сурвалж: National Bureau Statistics of China

Харин 2024 он гарснаас хойш эдийн засгийн өсөлт эхний хагас жилд 4.7%-р өсөж өмнөх улирлаас 0.6 нэгж хувиар бага байна. Хэрэглэгчдийн итгэл буурсан, иргэд хэрэглээндээ зарцуулалт хийхгүй байгаатай холбоотой Хятадын инфляц тасралтгүй буурсаар 2023 оны эцэст дефляцид орсон. Харин он гарснаас хойш инфляцын түвшин хангалттай хэмжээнд өсөхгүй байгаа бөгөөд 2024 оны 2-р улирлын байдлаар 0.2% байна. Хятадын засгийн газраас инфляцын зорилтот түвшнийг 3%-д барихаар зорьж байгаа бөгөөд эдийн засгийн идэвхжил, хэрэглээгч дэмжих чиглэлээр хэд хэдэн арга хэмжээнүүдийг авсаар байна. Тухайлбал эдийн засгаа дэмжих зорилгоор 1 их наяд юань буюу 138 тэрбум ам.долларын 20, 30, болон 50 жилийн хугацаатай засгийн газрын бондыг 2024 оны 5 сараас 11 сарын хооронд гаргаж дуусахаар хүлээгдэж байна.

Үл хөдлөх хөрөнгийн салбар нь БНХАУ-ын эдийн засгийн томоохон хөдөлгөгч хүч болж, ДНБ-ийх нь 30 орчим хувийг шууд бусаар бүрдүүлсээр ирсэн. 2020 оны 8-р сард Хятадын Засгийн газраас “гурван улаан шугам” шинэ бодлогыг танилцуулсан бөгөөд үүнд:


- Өр төлбөр, хөрөнгийн харьцаа 70 хувиас бага байх
- Цэвэр өр нь өөрийн хөрөнгийн 100 хувиас ихгүй байх
- Бэлэн мөнгө нь богино хугацааны өрийн хэмжээнээс их байх зэрэг шаардлагуудыг тавьсан.

Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийг хянах, барилгын компаниудын өрийн хэмжээг бууруулах, шинээр өр үүсгэхгүй байх зорилгоор энэхүү бодлогыг хэрэгжүүлж барилгын компаниудыг зээл авах, төлөх нөхцөлөө эргэн харахад хүргэсэн. Үүний жишээ нь үл хөдлөх хөрөнгийн хамгийн том компаниудын нэг болох Эвергранд компани бөгөөд хүүгийн төлбөрөө төлж чадахгүйд хүрч, 300 тэрбум ам.долларын өрөө хэрхэн төлж барагдуулах талаар хэлцэлд хүрч чадаагүй. Хэрэв Эвергранд компани дампуурвал урьдчилгаа төлбөрөө төлсөн олон орон сууц худалдан

авагч нь мөнгөө алдаж, ханган нийлүүлэгчдийнхээ төлбөрийг төлж чадахгүйд хүрэх юм. Харин Хонконгийн шүүхээс Эвергранд компанийг татан буулгах шийдвэрийг гаргаад байгаа билээ (Global Restructuring Review, 2024)

Харин үл хөдлөх хөрөнгийн салбараа дэмжих чиглэлээр Хятадын төв банк төрийн өмчид компаниудад 300 тэрбум юаньтай тэнцэхүйц санхүүжилт олгож үүгээр тус компаниуд баригдчихсан, зарагдаагүй байгаа орон сууцны худалдан авалтыг нэмэгдүүлэхээр зорьж байна.

БНХАУ Гадаад худалдаа YoY %



Эх Сурвалж: National Bureau Statistics of China

Цаашлаад дэлхийн хамгийн том үйлдвэрлэгч орны гадаад худалдааг авч үзвэл энэ оны 8 сард экспортын өсөлт 8.7%-д хүрсэн нь 2023 оны 3-р сараас хойш хамгийн хурдтай өсөлт болжээ. Харин нийт импортын өсөлт 2024 оны 8 сард 0.5%-тай, Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс (PMI) 49.1 болж, сүүлийн 4 сар дараалан тэлэлтийг илтгэх босго утга 50-с бага гарсан байна.


Хятад улсын хувьд цахилгаан авто машины зах зээлд давамгайл байдал тогтоохоор төлөвлөж байгаа бөгөөд нийт зах зээлийн 58%-ийг аль хэдийн бүрдүүлж байна. Экспорт нь Хятадын эдийн засгийг хөдөлгөгч гол хүч бөгөөд АНУ болон Европын Холбооны орнуудтай худалдааны хурцдахын хэрээр цахилгаан машинд ногдуулах татвар нэмэгдэж экспортод сөргөөр нөлөөлөх эрсдэл байсаар байна.

Мөн түүнчлэн, Хятадын гадаадын шууд хөрөнгө оруулалт 2023 онд 82.5%-р буурсан нь 1993 оноос хойших хамгийн доод түвшин болсон. Олон улс дахь хүүгийн түвшин өсөж хөрөнгө оруулагчид бусад төрлийн хөрөнгө оруулалтыг сонирхох болсон нь тус улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт буурах гол шалтгаан болсон. Мөн Хятад Тайванийн геополитикийн хурцадмал байдал ч мөн нөлөө үзүүлжээ. Үүнтэй холбоотойгоор Хятадын Засгийн газраас 2023 оноос эхлэн Бээжин болон Шанхай хотуудад татварын урамшуулал 2027 оныг дуустал хэрэгжүүлж, ил тод нээлттэй байдлыг сайжруулах замаар гадаадын хөрөнгө оруулагчдыг татах арга хэмжээг ч мөн авч байна (AGS, 2024)

Хятадын коксжих нүүрсний зах зээл

Хятад улсын нүүрсний хэрэглээ 2023 онд 4.5 тэрбум тоннд хүрч түүхэн дээд хэмжээнд хүрсэн бөгөөд нийт хэрэглээнийхээ 10%-ийг импортолжээ. Өнгөрсөн жилүүдийн импортын хэмжээ жилд дунджаар 6-7% байдаг байсан бол 2023 онд нийт хэрэглээний 10% болж өссөн нь дотоодын үйлдвэрлэл буурсантай холбоотой байна. Харин нүүрсний импортыг төрлөөр ангилж харвал коксжих нүүрсний импорт 103 сая тоннд хүрч өмнөх оноос 62%-р өсөж түүхэн дээд хэмжээнд хүрсэн бол эрчим хүчний нүүрсний импорт 371 сая тоннд хүрсэн байна.

Хятадын нүүрсний импорт /сая тн/




Эх Сурвалж: Блүүмберг терминал

Цаашлаад нийт коксжих нүүрсний импортын 67%-ийг манай улс бүрдүүлсэн бөгөөд үлдсэн хувийг ОХУ бүрдүүлжээ. Хятадын коксжих нүүрсний зах зээлд манай улс тэргүүлэх байр суурьтай байгаа ч өнгөрсөн жилүүдэд Австрали улсын импортын хэмжээ өндөр байсан бөгөөд Хятадын Австралид тавьсан хоригоос шалтгаалж тус улсын коксжих нүүрсний экспорт 2022, 2023 онуудад буурсан.

Харин он гарснаас хойш Хятадын коксжих нүүрсний импортын хэмжээ 78.7 сая тоннд хүрч сард дунджаар 9.8 сая тонн нүүрс импортолжээ. Харин тус импортод манай улсын эзлэх хувь сард дунджаар 50% байна. Тухайлбал эхний 8 сарын байдлаар Хятадын худалдан авсан нийт коксжих нүүрсний 44 орчим хувийг манай улс хангажээ.

Хятадын коксжих нүүрсний импорт сараар, 2024 оноос хойш



Эх Сурвалж: Блүүмберг терминал

Хэдийгээр үл хөдлөх хөрөнгийн салбар уналттай байгаа ч Хятадын манай улсаас авах нүүрсний импорт он гарснаас хойш тасралтгүй өслөө. Үүний гол шалтгаан нь Хятадын дотоодын үйлдвэрлэлийн бууралт хэрэглээний бууралтаас давсанд байгаа юм. Тодруулбал дэлхий нийтээр нүүрснээс татгалзаж, байгаль орчинд ээлтэй ногоон сонголтыг хийж эхэлж байгаатай холбоотойгоор Хятад улс ч мөн 2050 он хүртэл нүүрсхүчлийн хийн ялгаралтыг тэг болгох зорилттой. Үүнтэй холбоотой Хятадын нүүрсний хэрэглээ өнгөрсөн оноос 2%-р буурсан байна. Харин Хятадын нүүрсний уурхайнуудад гарч буй осол, гэмтэл, хяналт шалгалтын улмаас дотоодын үйлдвэрлэл өмнөх оноос 11%-р буурчээ. Ийнхүү Хятадын нүүрсний дотоодын үйлдвэрлэл нь нийт хэрэглээний бууралтаас өндөр байгаа тул хэрэглээгээ хангахын тулд нүүрсний импортоо өмнөх оноос нэмэгдүүлсээр байна.


ОХУ-ЫН ЭДИЙН ЗАСАГ

ОХУ-ын Украины дайнтай холбоотой хориг арга хэмжээг барууны орнууд авсаар байгаа ч Оросын эдийн засаг 2024 оны 2-р улиралд 4.1%-р өслөө. Цэргийн армийн зардлын өсөлтөөс шалтгаалсан төсвийн зардлын тэлэлт, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотойгоор тэлж байсан эдийн засаг ийнхүү саарч 2023 оны эхний улирлаас хойш хамгийн доод үзүүлэлтэд хүрсэн байна.

ОХУ-ын экспорт 2024 оны 2-р улиралд 1.4%-р өсөхөд газрын тос, байгалийн хийн үнийн өсөлт голлон дэмжсэн байна. Төв банкнаас 9 сард бодлогын хүүгээ 1%-р нэмэгдүүлж 19% болгосон бол инфляц 8 сарын байдлаар 9.1%-тай байна. Харин импорт өмнөх оны мөн үеэс 8.2%-р буурахад рублийн ханш суларч, геополитикийн хүндрэл үүссэн нь голлон нөлөөлжээ.

Мөн ОХУ-ын ерөнхийлөгчийн сонгууль энэ оны 3-р сарын 15-17-ний хооронд болж, Владимир Путин 87% санал авсан нь Зөвлөлтийн дараах үеийн түүхэн дэх хамгийн өндөр санал болжээ. Ийнхүү Владимир Путин дахин 6 жил ерөнхийлөгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхээр болсон нь зөвлөлтөөс хойш ОХУ-ын түүхэн дэх хамгийн урт хугацаанд төр барьж буй улс төрч болж байна (Reuters, 2024)

ОХУ-ын эдийн засгийн өсөлт




Эх Сурвалж: Trading Economics

Харин ОУВС-ийн төсөөллөөр ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2024 онд 2.9%, 2025 онд 1.4% болж буурах хүлээлттэй байна. Оросын түлш шатахууны зах зээлд АИ-95 төрлийн бензиний хомсдол үүсэж эхэлсэн ба Украины талаас Оросын газрын тос боловсруулах үйлдвэрүүд рүү удаа дараа довтолж, үйл ажиллагааг доголдуулж байгаагаар холбоотой. Энэ оны 6-р сард нийт газрын тос боловсруулах хүчин чадлын 15.5 хувь нь ажиллаагүй зогссон гэдгийг Ройтерсийн судалгаанаас мэдээлсэн. Энэхүү эрсдэл нь ОХУ шатахууны экспортдоо хориг тавих эрсдэлийг бий болгож байгаа ба хориг тавьснаар манай улсын шатахууны үнэ өсөж, инфляцыг хөөрөгдөх эрсдэлтэй.

ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХҮЛЭЭЛТ

Манай улсын эдийн засаг түүхий эдийн үнээс өндөр хамааралтай, олон улсын зах зээл дээрх нүүрс, зэсийн үнийн хэлбэлзэл эдийн засагт тодорхойгүй байдлыг нэмэгдүүлдэг. Геополитикийн хүндэрсэн нөхцөл байдал, инфляцын эрсдэлээс хамгаалах үйл ажиллагаа, Төв банкнуудын худалдан авалт зэргээс үүдэн алтны үнэ 2024 онд түүхэн дээд үнээ хэд хэдэн удаа шинээр тогтоолоо. Эдийн засагт тодорхойгүй байдал, дайн, улс хоорондын мөргөлдөөн нэмэгдэхийн хэрээр алтны үнэ өсөж байдаг. Олон улсын байгууллагуудын дундаж төсөөллөөр алтны үнэ 2024 оны эцэст \$2,685, 2025 онд \$2,724 байхаар хүлээгдэж байна.

Түүхий эдийн үнийн өөрчлөлт



Эх Сурвалж: Блүүмберг терминал

Сүүлийн жилүүдэд дэлхийн улсууд ногоон эрчим хүчний эх үүсвэрт шилжиж, зэсийн эрэлт нэмэгдэж байгаатай холбоотой зэсийн үнэ түүхэн дээд түвшиндээ хүрч өсөөд байна. Тухайлбал энэ оны 8 сарын байдлаар цэвэр зэсийн үнэ \$8,981 байна.

Цар тахлын үед дэлхийн нийтээр эрчим хүчний аюулгүй байдал чухлаар тавигдаж эхэлсэнтэй холбоотой нүүрсний хэрэглээ тасралтгүй өссөнөөр нүүрсний үнэ 447 ам.долларын давж түүхэн дээд түвшиндээ хүрч өссөн. Харин цар тахлын тэмцэл дуусаж улс орнууд нүүрсний хэрэглээгээ бууруулж, илүү байгаль орчинд ээлтэй сэргээгдэх эрчим хүчний чиглэлд анхаарч эхэлснээр нүүрсний хэрэглээгээ бууруулж байгаа нь үнэ буурахад голлон нөлөөлж байна. Үүнтэй холбоотойгоор олон улсын зах зээл дээрх нүүрсний үнэ тасралтгүй буурч 8 сарын байдлаар тонн тутамд 154 ам.доллартой тэнцэж буй юм.

Мөн цар тахлаас хойш дэлхийн хамгийн том газрын тос импортлогч БНХАУ-ын эрэлт буурсан тул газрын тосны үнэ буурч 2024 оны 8 сарын байдлаар тонн тутамд 79 ам.доллар байна. Олон улсын валютын сангийн таамаглалаар 2024 онд шатахууны үнэ дунджаар 9.7%, газрын тосны үнэ 2.5%-р буурах төлөвтэй байгааг тайлагнажээ. Үүний гол шалтгаан нь "ОПЕК+"-с бусад орнуудын (Канад, ОХУ гэх мэт) нийлүүлэлт нэмэгдсэнтэй холбоотой байна.

Геополитикийн тодорхойгүй нөхцөл байдал болон дэлхий дахин ногоон эрчим хүч рүү шилжиж байгаа тул 2024, 2025 онд алт, зэсийн үнэ өсөх хандлагатай байгаа бол нүүрс, газрын тосны үнэ буурах төлөвтэй байна.

The page features a large, light blue number '2' at the top center. Below it, the title is written in a clean, sans-serif font. The background is white, with abstract blue and yellow shapes on the left and bottom right. A thin yellow line curves around the bottom right shape. The bottom right shape is a large, dark blue, irregular polygon with a yellow triangle at its tip. Inside this shape is a lighter blue, textured area with a pattern of small dots and lines. The left side has a blue shape with a yellow triangle pointing right.

2

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2023 ОНЫГ ТОВЧ ДҮГНЭХҮЙ

Уул уурхайн салбар дээр тогтсон Монгол улсын эдийн засаг 2023 онд мөн л уул уурхайн салбарын сэргэлт, бусад уул уурхайгаас хамааралтай салбаруудын өсөлтийн үр дүнд эрчимжсэн билээ. Улмаар 2023 оны эцэст эдийн засгийн өсөлт 7.4 хувьтай гарсан бөгөөд 2.6 хувийг уул уурхайн салбар, 1.8 хувийг уул уурхайг дагасан тээврийн салбар дангаар бий болгожээ.

Нүүрсний экспорт сайжирч оны эцэст 67 сая тоннд хүрснээр валютын орох урсгал үнэмлэхүй нэмэгдэж төлбөрийн тэнцэл 2023 оны эцэст 1.5 тэрбум ам.долларын ашигтай гарсан. Ийнхүү 2022 онд жил дамнан алдагдалтай байсан төлбөрийн тэнцэл ашигтай гарснаар гадаад валютын албан нөөц түүхэн дээд хэмжээг давж 4.9 тэрбум ам.долларт хүржээ. Улмаар төгрөгийн ханш ам.долларын эсрэг 2023 оны 3-р сарын сүүлээс эхлэн чангарч оргил үедээ нэг ам.доллар 3,528 төгрөгт хүрээд байсан бол 2023 оны эцэст 3,410 төгрөгт хүртэл буурсан байна.

Харин инфляцын хувьд 2023 оны туршид барьсан мөнгөний хатуу бодлого болон олон улсад түүхий эдийн үнийн хөөрөл багассаны үр дүнд Монголбанкны зорилтот түвшинд хүрч жилийн эцэст 7.9 хувьтай гарчээ.

Цаашлаад 2023 онд түүхэнд байгаагүй өндөр буюу 22.4 их наяд төгрөгийн төсвийн зардалтай жил болж өнгөрсөн нь онцлох үйл явдал байв.

Ийнхүү 2023 оныг дүгнэвэл уул уурхайн салбарын СЭРГЭЛТТЭЙ, эдийн засгийн ӨСӨЛТТЭЙ, төсвийн өндөр ЗАРДАЛТАЙ, мөнгөний хатуу бодлого ҮРГЭЛЖИЛСЭН жил байлаа.

2024 оны сонгууль ба төсвийн их тэлэлт

2024 оны хувьд сонгуулийн жил болсон, тэр дундаа түүхэндээ анх удаа 126 гишүүн холимог тогтолцоогоор сонгогдсон болон хамтарсан засгийн газар байгуулагдсан гэдгээрээ онцлогтой байлаа.

Сонгуулийн үр дүнд

УИХ-ын ээлжит сонгууль 6-р сарын 28-нд болж өнгөрч Монгол Ардын намаас 68 суудал, Ардчилсан намаас 42 суудал, ХҮН намаас 8 суудал, Үндэсний Эвсэл намаас 4 суудал, Иргэний Зориг Ногоон намаас 4 суудал авснаар эрх баригч намаар 54 хувийн олонхын суудал авснаар Монгол Ардын нам тодорсон ба засгийн газар байгуулах эрхтэй болоод байсан билээ.

Хэдий тийм боловч нэг нам засгийн газар байгуулж, үлдсэн намууд сөрөг хүчин үүсгэхээс илүүтэйгээр ижил зорилготой, мөн хурдан үр дүнд хүрнэ гэсэн шалтгаанаар МАН, АН, ХҮН намууд нийлж хамтарсан засгийн газар байгуулах шийдвэр гаргасан. Улмаар Монгол Ардын нам ерөнхий сайд болон 12 сайд, Ардчилсан нам 8 сайд, ХҮН нам 2 сайдын суудал авч ирэх дөрвөн жилд 16 яамтай, 22 сайдын бүрэлдэхүүнтэйгээр ажиллахаар боллоо.

Хамтарсан засгийн газрын ирэх дөрвөн жилийн хугацаанд баримтлах бодлогод:


- Монгол Ардын намын мөрийн хөтөлбөрт туссан нийгмийн бодлогын шинэчлэл, бүсчилсэн хөгжлийн бодлого, авлигагүй төр, шударга ёсыг бэхжүүлэх цахим засаглал, эхлүүлсэн томоохон төсөл, арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зорилтууд,
- Ардчилсан намын мөрийн хөтөлбөрт туссан хүний хөгжил, хувийн өмчийн эрхийн хамгаалалт, технологи суурьтай мэдлэгийн эдийн засаг, бизнес, хөрөнгө оруулалтын орчин, эдийн засгийн эрх чөлөөг баталгаажуулах, шударга төрийн зорилтууд,
- ХҮН намын мөрийн хөтөлбөрт туссан эрчим хүчний болон боловсролын салбарын реформ, гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, төрийн худалдан авах ажиллагааны бодлогыг шинэчлэх, төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах зорилтуудыг тэргүүлэх чиглэл болгон тусгажээ. /Bloomberg, 2024/

ТӨСВИЙН ЭРГЭН ТОЙРОНД

Сонгуулийн жилийг дагаад төсвийн зардал 5 их наяд төгрөгөөр нэмэгдэж 27.4 их наяд төгрөгт хүрэх төсөөлөлтэй байсан бол 8-р сард тодотголын дараа ахин 3 их наяд төгрөгөөр нэмэгдэж 30 их наяд төгрөгийг давах төсвийн зардал батлагдлаа. Энэ нь Ковидын өмнөх 2019 онтой харьцуулахад 3 нугалсан үзүүлэлт болоод байна.

Төсвийн зардал болон 2024 оны нэмэгдэл зардлын задаргаа

■ 2024 оны төсвийн тодотгол ■ Төсвийн зардал ■ 2024 оны тодотголоос өмнөх зардал




Түүхэн статистикаас харахад сонгуулийн жилүүдэд төсвийн зардал дунджаар 30 хувиар өсдөг үр дүн бий. Үүний ч дагуу 2024 онд төсвийн зардал өмнө онтой харьцуулахад 8 их наяд төгрөгөөр буюу 35 хувиар өссөн байна. Зардлын өсөлтийг бүрэлдэхүүн хэсгээр нь авч үзэхэд цалингийн өсөлт 39 хувийг, барилга байгууламжийн хөрөнгө оруулалтын өсөлт 20 хувийг, тэтгэвэр тэтгэмж, урамшууллын нэмэгдэл 24 хувийг бусад хөрөнгө 14 хувийг бүрдүүлжээ.

2024 оны дөрөвдүгээр сард тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн ба төрийн албан хаагчдын цалинг 10-20 хувиар өсгөсөн нь ийнхүү төсвийн зардал өндөр байхад нөлөөлж байна. Цаашлаад ирэх жилүүдэд томоохон мега төслүүд хэрэгжүүлэх эхлэх хүлээлттэй байгаа ба төсвөөс нийт 120 их наяд төгрөгийн санхүүжилт шаардагдах юм.

Харин тодотголын дараах төсвийн орлого өмнөх жилтэй харьцуулахад 6.3 их наяд төгрөгөөр өссөн ба бүрэлдэхүүн хэсгээр задлан авч үзвэл 29 хувийг аж ахуй нэгжийн орлогын албан татварын өсөлт, 23 хувийг нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын өсөлт, 18 хувийг нийгмийн даатгалын орлогын өсөлт бүрдүүлжээ. Аж ахуй байгууллагуудын орлогын хэмжээ өссөнөөр орлогын өсөлтийн дийлэнх хэсгийг ААНБ-ын орлогын албан татвар бүрдүүлэх хүлээлттэй байгаа юм.


Нийт төсвийн орлого, зардал



Эх сурвалж: Сангийн Яам

Тодотголын дараах төсвийн орлого, зардлын задаргаа

Төсвийн нийт орлого, 2024T



Төсвийн нийт зардал, 2024T



Эх сурвалж: Сангийн Яам

Товчилсон үгийн тайлбар:

ОАТ-Орлогын албан татвар

НӨАТ-нэмэгдсэн өртгийн албан татвар


НДО-нийгмийн даатгалын орлого

АМНАТ-Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

Бүрэлдэхүүн хэсгээр авч үзвэл тодотголын дараах нийт төсвийн орлогын 28 хувийг ОАТ, 22 хувийг НӨАТ, 18 хувийг НДО, 15 хувийг АМНАТ орлого бүрдүүлж байна. Харин төсвийн нийт зардлын хувьд 67 хувийг тухайн жилдээ үрэгдээд дуусах урсгал шилжүүлэг буюу цалин, тэтгэвэр, тэтгэмж, татаас, халамжийн зардал эзэлж байгаа бол 26 хувийг хөрөнгийн зардал бүрдүүлж байна.

Цаашлаад 2025 онд төсвийн орлого 33.7 их наяд, зардал 35.6 их наяд төгрөгт хүрч төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1.9 их наяд төгрөгийн алдагдалд хүрэх төсөөлөлтэй байгаа юм. Харин үнэт цаас болон гадаад зээлийн эргэн төлөлтийг оруулахгүй тооцсон суурь тэнцэл 1.9 их наяд төгрөгийн ашигтай гарах хүлээлттэй байна.

Төсвийн орлогод уул уурхайн салбарын төвлөрүүлэх орлого



Эх сурвалж: Сангийн Яам


Цаашлаад уул уурхайн салбарын төсвийн орлогод төвлөрүүлдэг хувь нэмэр жил ирэх тусам нэмэгдэж байна. 2019 онд нийт төсвийн орлогын 24 хувь буюу 2.6 их наяд төгрөг зөвхөн уул уурхайн салбарын орлогоос бүрддэг байсан бол 2023 онд нийт төсвийн орлогын 32 гаруй хувийг уул уурхайн салбарын орлого бүрдүүлжээ. Уул уурхайн салбарын нийт орлогын 50 гаруй хувь нь АМНАТ-ын орлогоор орж ирдэг бол үлдсэн хувь нь уул уурхайн аж ахуй нэгж байгууллагын орлогын албан татвар хэлбэрээр орж ирдэг. Сүүлийн жилүүдэд уул уурхайн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр огцом өсөлттэй байсан ба 2023 оны эцэст 4.2 их наяд төгрөгт хүрсэн бол 2024 оны эцэст 4.4 их наяд хүрэх хүлээлттэй байна. Харин Ковидын өмнөх үед буюу 2019 онд АМНАТ-ын орлого ердөө 900 тэрбум хүрдэг байжээ.

2023 оны эцсийн гүйцэтгэлээр нийт төсвийн орлогод төвлөрүүлэх уул уурхайн салбарын орлогын 60 хувийг нүүрсний орлого, 30 хувийг зэсийн орлого бүрдүүлжээ. Нүүрсний экспорт 2023 онд үнэмлэхүй өссөний үр дүнд 2023 оноос өмнөх үеүдэд ихэвчлэн нүүрсний орлого зэсийн орлогоос бага эсвэл ойролцоо байдаг байсан бол 2023 онд нэг нугалсан үзүүлэлттэй байна. Уул уурхайн салбарын нөлөө төсвийн орлогод нэмэгдэхийн хэрээр эрсдэлийг нэмэгдүүлж байна. Учир нь түүхий эдийн үнэ олон улсын нөхцөл байдлаас ихээхэн хамааралтай байдаг ба уул уурхайн салбарын орлого түүхий эдийн экспортын орлогоос шууд хамааралтай.

Сангийн яамнаас 2024 оны төсвийн тодотголд орлогын төсөөллийг хийхдээ оны эцэст нүүрсний экспортын биет хэмжээг 78 сая тонн, хилийн үнийг 115 ам.долларт хүрэх хүлээлт тавьсан. 2024 оны 8-р сарын гүйцэтгэлээр нүүрсний хилийн үнэ 101 ам.доллар хүрч буурсан ба ирээдүйд илүү буурах хандлагатай байгаа юм. Тийм учраас сангийн яамны төсөөлөл хэт өөдрөг байж болох ба ийнхүү өндөр төсөөлөл тавих нь оны эцэст төсвийн орлого хүлээлтэд хүрэхгүй байх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

ЦАЛИН, ӨРХИЙН БОДИТ ОРЛОГО, ЗАРДАЛ

Нэрлэсэн, медиан, бодит цалингийн хэмжээ



Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо

2024 оны 4-р сард төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг 10-20 хувиар нэмэгдүүлсэн. Ийнхүү 2024 оны эхний хагас жилийн байдлаар нэрлэсэн дундаж цалингийн хэмжээ 2.5 сая төгрөгт хүрсэн ба Ковидын өмнөх буюу 2019 онтой харьцуулахад хоёр дахин өссөн үзүүлэлттэй байна. Хэдий тийм боловч худалдан авах чадварыг илэрхийлэх бодит цалингийн индекс ердөө 34 хувиар нэмэгджээ.

Инфляц өндөр байснаас шалтгаалж бараа бүтээгдэхүүний үнэ өссөн нь ийнхүү бодит цалингийн өсөлт нэрлэсэн цалинтай харьцуулахад доогуур гарахад нөлөөлсөн байна. Медиан цалингийн хувьд 2019 онтой харьцуулахад 2024 оны эхний хагас жилийн байдлаар 900 мянган төгрөг байснаас 2 сая төгрөгт хүрч 2.2 дахин өсжээ.

Дундаж цалин /салбараар/ 2024H1



Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо

Нийт ажилчдын тоо /салбараар/ 2024H1




Нийт ажилчдын тоо, 2024H1-1.3 сая

Салбараар нь ангилан авч үзэхэд 2024 оны эхний хагас жилийн байдлаар уул уурхайн салбарын ажилчдын цалин хамгийн өндөр буюу 5.1 сая төгрөгт хүрсэн бол хөдөө аж ахуйн салбарын ажилчдын цалин хамгийн доогуур буюу 1.9 сая төгрөг байна. Харин нийт ажилчдын тоонд эзлэх хувиар хөдөө аж ахуйн салбарт ажиллагчдын хувь хамгийн өндөр буюу 24 хувь байгаа бол уул уурхайн ажилчдын хувь ердөө 6 хувьтай байна.

Иймээс хэдий дундаж цалингийн хэмжээ 2.5 сая төгрөгт хүрсэн ч нийт хөдөлмөрийн зах зээлд ажил эрхлэгчдийн дийлэнх хэсгийг бүрдүүлэгч хөдөө аж ахуй, үйлчилгээ, худалдаа, боловсролын салбарт ажиллагчдын цалин дунджаас доогуур байгаа юм. Тиймээс илүү бодит үзүүлэлт нь медиан цалин ба 2024 оны эхний хагас жилийн байдлаар 2.0 сая төгрөгт хүрсэн байна. Энэ нь өмнө оны мөн үеэс 43 хувиар өссөн үзүүлэлт юм. 2023 оны эхний хагас жилд медиан цалин 1.4 сая төгрөг байжээ. Цалингийн хэмжээ ийнхүү өндрөөр өссөн нь дотоод эрэлтийг өдөөж эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлж байна.

Өрхийн бодит орлого, зарлагын өсөлт, ҮоҮ



Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо

Өрхийн орлогын 70 гаруй хувийг цалин хөлс болон тэтгэвэр, тэтгэмжийн орлого голлон бүрдүүлдэг. Иймээс 2024 онд цалингийн хэмжээ өссөн болон төсвийн тэлэлттэй холбоотойгоор тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ өндөр өсөлттэй байсан нь өрхийн орлого өсөхөд нөлөөлжээ.

Ийнхүү 2024 оны 2-р улирлын байдлаар бодит нийт орлогын хэмжээ 1.7 сая төгрөгт хүрч өмнөх онтой харьцуулахад 17.3 хувиар өссөн ба бодит зардал 1.8 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 13.6 хувиар өсжээ. Жилийн өмнө буюу 2023 оны 2-р улиралд бодит орлого ердөө 1.5 хувийн өсөлттэй байсан бол бодит зардал 9.9 хувийн өсөлттэй байв.

Бүрэлдэхүүн хэсэгт хуваан авч үзэхэд бодит орлогын өсөлтөд цалин хөлсний бодит орлого 218.3 (31.2%) мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн бол бодит нийт зардалд хүнсний бус бараа, үйлчилгээний бодит зарлага 184.2 (18.9%) мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Өрхийн бодит орлого өссөнөөр хэрэглэх хандлага нэмэгдэж бодит зардал даган өсөж улмаар дотоод эрэлтийг өдөөж байна.

Өрхийн орлого нэмэгдэхийн сацуу аж ахуй нэгж байгууллагуудын ашигт ажиллагаа сайжирч ногдол ашиг тарааснаар мөн дотоод эрэлтийг нэмэгдүүлж буй юм. Тухайлбал Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компаниуд нийт 799 тэрбум төгрөгийн ногдол ашиг 2024 онд тараах хүлээлттэй байгаа ба Эрдэнэс тавантолгой ХК-ийн 1072 ширхэг хувьцааны ногдол ашгийн нийт хэмжээ 1.1 их наяд төгрөг байна. Үүний 290 тэрбум нь 2022 оны ашиг бөгөөд энэ оны 1 болон 4-р сард нийт 360 мянган төгрөгийн ногдол ашгийг 1072 ширхэг хувьцаатай иргэн бүрт тараасан.

ГАДААД ХУДАЛДАА


Экспорт, импортын өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Төсвийн өндөр зардал болон цалин, хөлсний нэмэгдэл, ногдол ашгийн олголтоос шалтгаалж 2024 онд дотоод эрэлт өсөж импортын өсөлтөд голлон нөлөөлжээ. 2024 оны эхний 8 сарын байдлаар нийт импорт 26 хувиар өссөн ба өсөлтийн 13 хувийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн тэр дундаа 10 хувийг тээврийн хэрэгслийн импортын өсөлт бүрдүүлсэн байна. Тодруулбал эхний 8 сарны байдлаар Япон улсаас нийт 76 мянган суудлын машин импортолсон нь 2023 оны жилийн туршид импортолсон 68 мянган суудлын автомашиныг эхний 8 сарын хугацаанд давсан үзүүлэлт юм. Цаашлаад импортын 26 хувийн өсөлтийн 8 хувийг хэрэглээний бүтээгдэхүүний импортын өсөлт, 3 хувийг шатахууны импортын өсөлт бүрдүүлсэн байна.

Нүүрсний экспортын биет хэмжээ, хилийн дундаж үнэ




Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Харин өмнө оны мөн үетэй харьцуулахад нийт экспорт ердөө 6 хувиар өссөн нь жилийн өмнөх 30 хувийн өсөлтөөс хэд дахин доогуур байна. 2024 оны эхний 8 сарын байдлаар нүүрсний биет хэмжээ 54 сая тоннд хүрсэн ба сангийн яамны төсөөллөөр 2024 оны эцэст 78 сая тоннд хүрэх хүлээлттэй байна. Нүүрсний биет хэмжээ өндөр байгаа хэдий ч хилийн үнэ буурсан хэвээр байгаа нь ийнхүү экспортын өсөлтийг хязгаарлаж буй юм. Тухайлбал 2024 оны 8-р сарын байдлаар нүүрсний хилийн үнэ тонн тутам нь 100.5 ам.доллар байгаа ба энэ тоо цаашид буурах хүлээлттэй байна. Нүүрсний хилийн үнэ 2022 оны 11-р сард хамгийн өндөр буюу оргил үедээ 366 ам.долларт хүрч байжээ. Цаашлаад зудаас шалтгаалсан мал, аж ахуйн бүтээгдэхүүний экспортын бууралт нийт экспортыг 1.1 хувиар доош татсан байна.

Харин уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нийт экспортыг дэмжиж өсөлтийн 3.9 хувийг нүүрсний экспортын өсөлт бүрдүүлсэн бол 2 хувийг зэс, 1.6 хувийг алтны экспорт бүрдүүлжээ.

Нийт экспорт, импорт




Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Ийнхүү импортын өсөлт эрчимжиж, экспортын өсөлтийн хурд буурч эхэлсний нөлөөгөөр гадаад худалдааны тэнцэл эхний 8 сарын байдлаар өмнө оны мөн үеэс 22 хувиар буурч 3.1 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

Нийт экспорт болон импортын хэмжээ, бүрэлдэхүүн хэсгүүдээр

Нийт экспорт, 2024-Aug



Нийт импорт, 2024-Aug




Эх сурвалж: Монголбанк

Бүрэлдэхүүн хэсгээр нь авч үзэхэд нийт экспортын 93 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн, тэр дундаа нүүрс 57 хувийг, зэс 18 хувийг, алт 5 хувийг голлон бүрдүүлсэн байна. Цаашлаад 4 хувийг мал аж, ахуйн бүтээгдэхүүнүүд үлдсэн хувийг аж үйлдвэрлэл болон газар тариалангийн экспорт бүрдүүлжээ. Зудаас шалтгаалсан газар тариалан болон мал аж, ахуйн экспортын бууралт нийт экспортод сөргөөр нөлөөлсөн байна.


Харин нийт импортын хувьд 43 хувийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнүүд буюу машин механизм, тээврийн хэрэгсэл болон барилгын материалын импорт бүрдүүлсэн байна. Цаашлаад 29 хувийг түргэн болон удаан эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүний импорт, 19 хувийг дизел түлш, АИ-92, 95 бинзен зэрэг нефтийн бүтээгдэхүүнүүд, 8 хувийг аж үйлдвэрийн орцын импорт бүрдүүлжээ.

УРСГАЛ ТЭНЦЭЛ, ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГВАН, ХАНШ


УРСГАЛ ДАНС
сая USD




ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ
сая USD



ГВАН
сая USD



ХАНШ
сая USD



Эх сурвалж: Монголбанк

Уул уурхайн салбарын өсөлтийн ачаар 2023 онд валютын орох урсгал нэмэгдэж төлбөрийн тэнцлийн нэг хэсэг урсгал дансны тэнцэл 2007 оноос хойш анх удаа ашигтай гарсан билээ. Улмаар төлбөрийн тэнцэл 2023 оны эцэст 1.5 тэрбум ам.долларын ашигтай гарсан хэдий ч 2024 оны эхнээс импортын барааны өсөлт эрчимжиж валютын гарах урсгал нэмэгдсэнээр урсгал дансны тэнцэл ахин алдагдалтай гарсны улмаас эхний 7 сарын байдлаар төлбөрийн тэнцэл 136 сая ам.долларын алдагдалд хүрэв.

Төлбөрийн тэнцэл буурч байгаа нөлөөгөөр гадаад валютын албан нөөц 5-р сард 5.2 тэрбум ам.долларт хүрч түүхэн дээд хэмжээг даваад байсан бол гурван сар дараалан буурч 8-р сард 4.7 тэрбум ам.доллартой гарав. Ийнхүү 2024 он гарснаас хойших хамгийн доогуур хэмжээнд хүрлээ. Монголбанкнаас 5-р сард Хятадын ардын банкт хийсэн своп хэлцлээс 4.5 тэрбум юань буюу 617 сая ам.долларын своп арилжаа хийснээ мэдээлсэн ба энэ нь нөөцийн хэмжээ ийнхүү буурахад мөн нөлөөлжээ. Цаашлаад эхний 8 сарын байдлаар валютын нөөцийн хэмжээ дунджаар 5 сарын импортыг хангах түвшинд байна. Энэ тоо 2020 онд хамгийн өндөр буюу эхний хагас жилийн байдлаар 8 сарын импортыг хангах түвшинд байжээ.

Нөөцийн хэмжээ буурч эхэлсэн учраас 2023 оны 8-р сараас хойш тасралтгүй чангарч байсан төгрөгийн ханш тогтворжиж 2024 он гарснаас хойш 8 сарын хугацаанд нэг ам.долларт 3'380-3'400 төгрөг орчимд хэлбэлзэж байна.

БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

Банкуудын зээлийн өсөлт 2024 оны 7 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 32.1%-иар өсөж 33.2 их наяд төгрөгт хүрчээ. Зээлийн үлдэгдэл нь шинээр олгосон зээлээр нэмэгдэж, эргэн төлөлтөөр буурч байдаг. 2019 оноос хойш жилд 2-3 их наяд төгрөгөөр нэмэгддэг байсан зээлийн үлдэгдэл энэ оны эхний 7 сарын байдлаар 6 их наяд төгрөгөөр нэмэгдсэн байна. Эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн банкны салбарын зээлийн өсөлт ийнхүү өндөр байгаа нь төрөөс хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүд болон эдийн засгийн идэвхжилтэй холбоотой байна.


Түүнчлэн банкны салбарын харилцах, хадгаламж 28.9%-иар өсөж 38.4 их наяд төгрөгт хүрчээ. Төгрөгийн ханш харьцангуй тогтвортой байгаа нь төгрөгийн бодит өгөөжийг нэмэгдүүлж, төгрөгийн хадгаламж өсөхөд голлон нөлөөлж байгаа бөгөөд төгрөгийн хадгаламжийн өсөлт энэ оны 7 сарын байдлаар 39% байна. Төгрөгийн харилцах 11.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 54.5%-иар өссөн байна.

Банкны салбарын зээл, харилцах хадгаламжийн үлдэгдэл



Эх сурвалж: Монголбанк

Зээлийн үлдэгдэл, эдийн засгийн салбараар




Эх сурвалж: Монголбанк

Зээлийн үлдэгдэл он гарснаас хойш 7.1 их наяд төгрөгөөр нэмэгдэхэд үйлчилгээний салбарын зээл 2.1 их наяд төгрөгөөр тэр дундаа үл хөдлөх хөрөнгийн салбарын зээл 1.2 их наяд төгрөгөөр буюу 30.2%-иар, худалдааны салбарын зээл 592 тэрбум төгрөгөөр буюу 10.9%-иар өссөн нь голлон нөлөөлжээ.

Илүү нарийвчлан авч үзвэл 2024 оны эхний 8 сарын байдлаар худалдааны салбарын зээлийн үлдэгдэл хамгийн өндөр байгаа ба 6.0 их наяд төгрөгт хүрчээ. Харин үл хөдлөх хөрөнгийн салбарын зээл 5.1 их наяд төгрөгт хүрсэн бол боловсруулах үйлдвэрлэлийн салбарын зээл 2.4 их наяд төгрөг байна.

Иргэдэд олгосон хэрэглээний зээлийн үлдэгдэл




Эх сурвалж: Монголбанк

Иргэдийн цалин, тэтгэврийн өсөлт нь өрхийн орлогыг нэмэгдүүлэхээс гадна хэрэглээний зээлийн өсөлтийг нэмэгдүүлж байна. Иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл энэ оны эхний 8 сарын байдлаар 20.4 их наяд төгрөг байгаа бөгөөд зээлийн үлдэгдлийн 54.3%-ийг хэрэглээний зээл бүрдүүлж байна. Хэрэглээний зээл өмнөх оны мөн үеэс 37.8%-иар өсөж 11.0 их наяд төгрөгт хүрэхэд цалингийн зээл 50.7%-иар өсөж 5.8 их наяд төгрөгт, тэтгэврийн зээл 52.2%-иар өсөж 1.6 их наяд төгрөгт хүрсэн нь голлон нөлөөлжээ. Мөн өрхийн хэрэглээний зээл өмнөх оны мөн үеэс 72%-иар өсөж 467 тэрбум төгрөгт, малчны зээл 9.3%-иар өсөж 1.4 их наяд төгрөгт хүрсэн бол хадгаламж барьцаалсан зээл 15.6%-иар өсөж 1.4 их наяд төгрөгт хүрчээ.

Ийнхүү нийтэд нь авч үзэхэд нийт зээлийн 7,1 их наяд төгрөгийн өсөлтийн 37 хувийг хэрэглээний зээлийн өсөлт, 30 хувийг үйлчилгээний салбарын зээлийн өсөлт, 8 хувийг худалдааны салбарын зээлийн өсөлт голлон бүрдүүлжээ. Өөрөөр хэлбэл нийт зээлийн өсөлтийн 75 хувийг зөвхөн хэрэглээ, үйлчилгээ, худалдааны салбарын зээлийн өсөлт бий болгожээ. Үүний шалтгааныг голчлон авч үзвэл цалин, тэтгэврийн өсөлт хэрэглээний зээлийг өдөөсөн бол дотоод хэрэглээ эрчимжсэнээр худалдаа, үйлчилгээний салбарын өсөлтийг хурдасгаж улмаар зээл тэлэлтийг нэмэгдүүлжээ.

ИНФЛЯЦ, МӨНГӨНИЙ БОДЛОГО

Инфляц, бодлогын хүү




Зээлийн өсөлт түүхэнд байгаагүй өндөр хэмжээнд өссөнөөр Монголбанкнаас мөнгөний олон талт арга хэмжээг хэрэгжүүлж байна.

2021 онд 13.8 хувь хүртэл өсөөд байсан инфляцын түвшин мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлж эхэлснээр 2023 оноос эхлэн буурав. Ийнхүү 2024 оны 8-р сард инфляцын түвшин 6.5 хувьд хүрснээр сүүлийн 9 сарын турш Монголбанкны зорилтот 6 +/-2 түвшинд хэвээр хадгалагдлаа. Монголбанкнаас инфляц төсөөллөөс хурдан хугацаанд буурч байгаа учраас 2024 он гарснаас хойш бодлогын хүүг 3 удаа бууруулж 10 хувьд хүргээд байна. Хэдий бодлогын зөөлөн арга хэмжээг аажмаар авч байгаа ч нөгөө талдаа зээлийн өсөлт түүхэнд байгаагүй өндөр хэмжээнд хүрсэн болон хэрэглээний өсөлт инфляц хөөрөгдөх эрсдэлийг бий болгож байгаа учраас бодлогын олон талт арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Тиймээс бодлогын хүүг 9-р сарын мөнгөний бодлогын хорооны хурлаар нэг нэгж хувиар бууруулсан ч хүүгийн коридорыг нэмэгдүүлж +/-2 нэгж хувьд хүргэв. /Тайлбар: Монголбанкнаас банк хоорондын захын жигнэсэн дундаж хүүг бодлогын хүү орчимд хадгалж, мөнгөний бодлогын шилжих механизмыг сайжруулах зорилгоор бодлогын хүүтэй уялдуулан хүүгийн коридор системийг ашигладаг энэхүү систем нь бодлогын хүүгээс тодорхой интервалд байгуулагддаг/. Улмаар төв банканд байршуулах хадгаламж 8 хувийн хүүтэй тооцогдох бол авах зээлийн зардал өсөж 12 хувьд хүрч байгаа юм. Улмаар арилжааны банкнууд төв банкнаас авах зээлийн зардал буураагүй ч байршуулснаар хүртэх өгөөжийн хувь хэмжээ өмнөх үеэс буурав.

Мөн түүнчлэн төгрөгийн заавал байлгах нөөцийн хэмжээг 8 хувиас 2 нэгж хувиар нэмэгдүүлж 10 хувьд хүргэлээ. Улмаар бодлогын хүү буурснаас шалтгаалан гарах боломжтой байсан зээлийн хэмжээг заавал байлгах нөөцөд шилжүүлэн байршуулах юм.

Хадгаламж, зээлийн хүү




Бодлогын хүү буурснаар онолын хүрээнд арилжааны банкнуудын зээл, хадгаламжийн хүү даган буурах хүлээлттэй байдаг. Гэсэн хэдий ч Монголбанкны зүгээс бодлогын олон талд арга хэмжээ авснаар банкнуудын зардал өссөн учраас зээлийн хүү буурах нөлөө багасаж, улмаар хадгаламжийн хүү буурахгүй хэвээр байна. Тиймээс он гарснаас хойш бодлогын хүү хэдий 3 удаа буурсан ч зээл болон хадгаламжийн хүү өндөр түвшинд хэвээр хадгалагдаж байна. 2023 оны эцэст төгрөгийн зээлийн хүү 16.7 хувьтай байсан бол 8 сарын дараа дунджаар 17 хувьтай байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

2023 оны хувьд уул уурхайн өсөлтөөр эрчимжсэн эдийн засгийн өсөлттэй жил байсан бол 2024 онд уул уурхайн салбарын өсөлтийн нөлөө буурч дотоод хэрэглээ түүнээс үүдэн үйлчилгээ, худалдааны салбарын өсөлт голлон эдийн засгийн өсөлтийг бүрдүүлж байна.


2023 оны эцэст эдийн засгийн өсөлт 7.4 хувьд хүрсэн бол өсөлтийн хурд харьцангуй буурч 2024 оны эхний хагас жилд 5.6 хувьтай гарлаа. Нүүрсний үнэ олон улсын зах зээл дээр буурч байгаа нөлөөгөөр экспортын өсөлт буурч улмаар уул уурхайн салбарын идэвхжил багасаж байгаа нь ийнхүү эдийн засгийн өсөлтийн хурд саарахад нөлөөлжээ. Эдийн засгийн өсөлтөд уул уурхайн салбарын нөлөө өндөр хэвээр байгаа ч гол нөлөөллийг худалдаа, үйлчилгээний салбар бий болгожээ.

Эдийн засгийн өсөлт




Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо

Эдийн засгийн өсөлт (үйлдвэрлэлийн аргаар), 2024-H1



Эдийн засгийн өсөлт (зардлын аргаар), 2024-Н1



Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо

Эдийн засгийн өсөлтийг салбараар нь ангилан авч үзвэл үйлчилгээний салбар 2.1 хувийг, уул уурхайн салбар 1.8 хувийг, тээврийн салбар 1.0 хувийг, худалдааны салбар 0.7 хувийг голлон бүрдүүлсэн байна. Харин хүйтэн өвлийн дараах зудаас шалтгаалсан ХАА-н салбарын уналт 2024 оны эхний хагас жилд эдийн засгийн өсөлтийг 3.9 хувиар доош татсан байна. Статистикаас дурдахад малын зүй бус хорогдлын хэмжээ 2023 оны эцэст 5 сая толгойд хүрсэн ба хонь, ямааны толгойн хорогдол хамгийн өндөр буюу тус бүр хоёр сая толгойг давжээ. /Статистикийн хороо, 2023/

Цаашлаад эдийн засгийн өсөлтийг зардлын аргаар тооцон үзэхэд 2024 оны эхний хагас жилд 5.8 хувиар өссөн ба өрхийн хэрэглээ өсөлтийн 12.1 хувийг, засгийн газрын хэрэглээ 9.3 хувийг, хөрөнгийн хуримтлал 6.2 хувийг голлон бүрдүүлсэн ба цэвэр экспорт бууралт өндөртэй байсан ба өсөлтийг 22 хувиар доош татжээ.

2024 онд цалин хөлсний хэмжээ нэмэгдэж өрхийн орлого өссөнөөр зардал даган өсөж өрхийн хэрэглээ нэмэгдсэн. Үүнээс шалтгаалж эдийн засгийн өсөлтөд өрхийн хэрэглээний нөлөө өндөр байв. Мөн түүнчлэн 2024 онд төсвийн зардал үнэмлэхүй өсөж 30 их наяд төгрөг хүрэх төсөөлөлтэй байгаа ба үүнээс шалтгаалан засгийн газрын хэрэглээ эдийн засгийн өсөлтөд голлон нөлөөлсөн байна.

Харин нүүрсний үнэ буурсан болон зудаас шалтгаалан мал аж, ахуйн бүтээгдэхүүний экспорт буурсан нь нийт экспортын өсөлтийг хязгаарласан бол нөгөө талдаа дотоод эрэлтийн өсөлтөөр импортын өсөлт эрчимжсэн нь цэвэр экспортыг бууруулж эдийн засгийн өсөлтийг 22 хувиар доош татахад нөлөөлжээ.

Ийнхүү 2024 оны эдийн засгийн нөхцөл байдлыг эхний 8 сарын байдлаар товч дүгнэхэд сонгуулийн жилийн данхар ТӨСӨВТЭЙ, өрхийн бодит орлого ӨССӨН, ААНБ-ын ашигт ажиллагаа НЭМЭГДЭЖ ногдол ашиг ТАРААСАН, улмаар дотоод хэрэглээ ЭРЧИМЖИЖ богино хугацаанд эдийн засгийн өсөлтийг БИЙ БОЛГОСОН хэдий ч нэг талаас импортын өсөлт ӨДӨӨГДСНӨӨР урсгал дансны тэнцэл АЛДАГДАЛД ХҮРЧ валютын нөөц БУУРСАН бол нөгөө талаас зээл олголт ТҮҮХЭН ДЭЭД ХЭМЖЭЭГЭЭР ӨСӨЖ, мөнгөний бодлогыг зөөлрүүлэхээс илүүтэй бодлогын олон талт АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖҮҮЛСЭН жил болоод байна.

The page features abstract geometric shapes in various shades of blue and yellow. In the top left, there is a dark blue shape and a light blue triangle with a yellow triangle pointing towards it. A large, dark blue shape with a yellow triangle and a yellow line is in the bottom right. The central text is positioned between these graphic elements.

3


ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРУУД

Манай улсын эдийн засгийн засгийн өсөлт 2024 оны эхний хагас жилд нэрлэсэн дүнгээр 37.4 их наяд төгрөгт хүрч харин 2015 оны зэрэгцүүлэх үнээр бодитоор 5.6%-иар өслөө. Эдийн засгийн өсөлтөд үйлчилгээний салбар 4.4%-ийн эерэг нөлөө үзүүлсэн бол ХАА салбар 3.9%-ийн сөрөг нөлөө үзүүлсэн байна. Он гарснаас хойш нүүрсний экспортын биет хэмжээ 8 сарын байдлаар 53.7 сая тоннд хүрсэн нь уул уурхайн салбарын идэхжилд голлон нөлөөлж, уул уурхайн салбар өмнөх оны мөн үеэс 15.4%-иар өсөж эдийн засгийн өсөлтийн 1.8%-ийг бүрдүүлсэн байна. Цаашлаад ажиллагсдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой бодит орлого нэмэгдэж үйлчилгээний салбар тэр дундаа бөөний болон жижиглэн худалдааны салбар идэвхжиж тус салбар өмнөх оноос 9.6%-иар өссөн бол үйлдвэрийн салбар бүхэлдээ 7.9%-иар өсөж эдийн засгийн өсөлтөд 0.8%-ийн эерэг нөлөө үзүүлжээ.

БДНБ, эдийн засгийн салбараар

*Худалдаа, Тээвэр, Мэдээлэл Холбоо болох Үйлчилгээний бусад салбарууд

**Боловсруулах, Цахилгаан, Барилгын салбарууд



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Эхний хагас жилийн байдлаар малын зүй бус хорогдлын тоо 8.1 саяд хүрсэн нь хөдөө аж ахуйн салбарын өсөлтийг хойш татаж, эхний хагас жилд 26.7%-иар агшиж эдийн засгийн өсөлтийг 3.9%-иар хойш нь татлаа.

Инженерийн дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалтуудын нөлөөгөөр барилгын салбар эхний хагас жилд 19.5%-иар өсөж, хүнсний зарим нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдсэнээр боловсруулах салбар 6.3%-иар тэлжээ.

УУЛ УУРХАЙ БА ТЭЭВРИЙН САЛБАР


Үйлдвэрлэлийн салбарт уул уурхай, олборлолт, боловсруулах, цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж, усан хангамж, барилгын салбарыг хамруулах бөгөөд уг салбар нь ДНБ-ий 40 орчим хувийг бүрдүүлдэг чухал салбар юм.

Уул уурхайн салбар нь аж үйлдвэрийн салбарын 70%-ийг дангаар бүрдүүлдэг бол тээврийн салбар нь үйлчилгээний салбарт харьяалагддаг бөгөөд үйлчилгээний салбарын 12%-ийг бүрдүүлдэг. Уул уурхай болон тээврийн салбар нь хоорондоо эерэг хамааралтай бөгөөд тээврийн салбараар тээсэн нийт ачаа тээвэр нь уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэртэй нягт холбоотой. Өөрөөр хэлбэл уул уурхайн салбарын идэвжил тээврийн салбарыг өсөхөд голлон нөлөөлдөг. Тиймдээ ч өнгөрсөн онд 69.6 сая тонн нүүрс экспортолсон нь тээврийн салбарын орлого өнгөрсөн онд 52%-иар өсөхөд голлон нөлөөлсөн.

2023 оны эцэст уул уурхайн салбарын бүтээгдэхүүний нийт борлуулалт 36.6 их наяд төгрөгт хүрч байсан бол энэ оны 7 сарын байдлаар 23.7 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 22.1%-иар өссөн байна.

2023 оны эцсээр уул уурхайн салбарын орлогын 59.3%-ийг нүүрс бүрдүүлсэн байгаа бол металлын хүлэр олборлолтын орлого 36%, газрын тосны олборлолт 3.4%-ийг бүрдүүлжээ.

Уул уурхайн салбарын орлогод эзлэх%, 2023 оны эцсээр



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Цаашлаад аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл энэ оны 7 сарын байдлаар 18.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 15.7%-иар өсжээ. Ийнхүү өсөхөд уул уурхайн салбарын үйлдвэрлэл 2.2 их наяд төгрөгөөр буюу 20%-иар өсөж 13.2 их наяд төгрөгт хүрсэн нь голлон нөлөөлсөн байна. Уул уурхайн салбарын олборлолтын өсөлт дийлэнх нь буюу 95% нь чулуун болон хүрэн нүүрс олборлолтоос бий болсон бөгөөд 8 сарын байдлаар чулуун нүүрс олборлолт биет хэмжээгээр 53.7 сая тоннд хүрч өмнөх оноос 30%-иар өсжээ. Манай улсын засгийн газраас нүүрсний экспортын биет хэмжээг энэ оны эцэст 78 сая тоннд, ирэх онд 83 сая тоннд хүргэх төлөвлөгөөтэй байгаа билээ.

Харин манай улсын нийт экспорт өнгөрсөн оны эцэст 15.2 тэрбум ам.долларт хүрч түүхэн дээд хэмжээнд хүрсний 58%-ийг нүүрсний экспорт бүрдүүлж, 17%-ийг зэсийн экспорт бүрдүүлж байсан. 2024 он гарсан ч энэхүү тренд хэвээр байгаа буюу эхний 7 сарын байдлаар нийт экспорт 9.2 тэрбум ам.долларт хүрсний 5.3 тэрбум ам.долларын орлого нь нүүрсний экспортоос, 1.7 тэрбум нь зэсийн экспортоос бий болжээ. Ийнхүү зэс болон нүүрс нь манай улсын эдийн засгийн тулгуур хэвээр байна.


Уул уурхайн салбарын борлуулалтын орлогын өсөлт, YoY



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Нөгөө талдаа гол худалдан авагч Хятад улсын нүүрсний хэрэглээ он гарснаас хойш тасралтгүй буурч байгаа боловч дотоодын нүүрсний үйлдвэрлэл нь хэрэглээний бууралтаас өндөр байгаа тул импортын хэмжээ өмнөх оноос өссөөр байна.

Нүүрсний экспорт сараар, сая тонн



Эх сурвалж: Монголбанк

Нүүрсний экспортын хэмжээг сараар, өмнөх онтой харьцуулж харвал биет хэмжээгээр тасралтгүй өссөн байна. Тухайлбал 8 сард 7.6 сая тонн нүүрс экспортолсон нь өмнөх оны 8 сартай харьцуулахад 10%-иар өссөн байна. Харин хуримтлагдсан дүнгээр 53.7 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 13 сая тонн-р өссөн байна. Түүнчлэн өнгөрсөн онд сард дунджаар 5.1 сая тонн нүүрс экспортолж байсан бол он гарснаас хойш сарын дундаж экспортын хэмжээ 6.7 сая тонн болж өсжээ.

Харин цар тахлын үеэр түүхэн дээд хэмжээнд хүрч өсөөд байсан нүүрсний үнэ он гарснаас хойш тасралтгүй буурч 8 сарын хилийн үнэ 100.5 ам.доллар орчимд байна. Дэлхийн банкны төсөөллөөр Австралийн кокжих нүүрсний үнэ 2024 оны эцэст тонн тутамд 125 ам.доллар, 2025 оны эцэст 110 ам.доллар байна гэж төсөөлжээ.


Нүүрсний хилийн үнэ, ам.доллар



Эх сурвалж: Монголбанк

Тээврийн салбарын орлого 2023 оны эцэст 6.7 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 2.3 их наяд төгрөг буюу 52.1%-иар өссөн байна. Тээврийн төрлөөр салган харвал агаарын тээврийн орлого өмнөх оны мөн үеэс 83.6%-иар өсөж 941.9 тэрбум төгрөг, төмөр замын тээврийн орлого 50.3%-иар өсөж 1,124.9 тэрбум төгрөг хүрсэн бол авто замын тээврийн орлого 47.3%-иар өсөж 4,676.4 тэрбум төгрөг хүржээ.


Тээврийн салбарын борлуулалтын орлогын өсөлт, ҮoY



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо


Тээврийн салбарын нийт орлогын 69.3%-ийг авто тээврийн салбар бүрдүүлсэн бол төмөр зам 16.7%, агаарын тээвэр 14.0%-ийг тус бүр бүрдүүлжээ. Харин 2023 онд нийт 102.3 сая тонн ачаа тээсэн нь өмнөх оноос 41.5 сая тонноор их буюу 68.2%-иар өссөн байна. Үүний 69.9 сая тонн ачаа нь авто замаар тээвэрлэгдсэн бол 32.4 сая тонн буюу 31.7% нь төмөр замаар тээвэрлэгдсэн байна.

Тээврийн салбарын нийт орлого 2023 он: 6,744.7 тэрбум төгрөг



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо


Нийт тээсэн ачаа 2023 он: 102.3 сая тонн



Цаашлаад авто тээврээр тээсэн нийт ачаа тээврийн дийлэнх нь буюу 66.9 (95.7%) сая тонн нь уул уурхайн бүтээгдэхүүний тээвэр байна.

Харин 2024 он гараад эхний хагас жилийн байдлаар тээврийн салбарын нийт орлого 3.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 24.8%-иар өсжээ. Бүх төрлийн тээврээр нийт 55.6 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 23.1%-иар өсжээ.

Зорчигчдын тоо, тээврийн төрлөөр сая хүн



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Бүх төрлийн тээврээр зорчсон зорчигчдын тоо 2023 онд 147 сая хүрч өмнөх оноос 0.5%-иар өссөн байна. Зорчигчдын тоо өсөхөд агаарын тээврээр зорчигчид өмнөх оноос 87.7%-иар өсөж 1.7 саяд хүрсэн нь голлон нөлөөлсөн байна. Харин төмөр замаар зорчсон зорчигчдын тоо 2023 оны эцэст 2.2 сая болж өмнөх оноос 226.0 мянгаар буюу 9.5%-иар буурсан байна. Энэхүү бууралтад орон нутгийн зорчигчид 230.2 мянгаар буурсан нь голлон нөлөөлжээ.

Уул уурхай ба тээврийн салбарын БДНБ-ий өсөлт, ҮоҮ



*Төсөөлөл


Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, Голомт банк

Тээврийн салбарийн нийт тээсэн ачаа тээврийн дийлэнхийг уул уурхайн бүтээгдэхүүн бүрдүүлдэг тул тээврийн салбарын өсөлт уул уурхайн салбараас, тэр дундаа нүүрсний тээврээс өндөр хамааралтай. 2023 онд нийт 66.7 сая коксжих нүүрс тээвэрлэсэн нь тээврийн салбарын өсөлтөд голлох нөлөө үзүүлж 39.6%-иар өсгөжээ. Харин уул уурхайн салбарын бодит өсөлт 23.4%-д хүрсэн байна. Энэ онд нүүрсний биет хэмжээ өмнөх онтой харьцуулахад өссөн, мөн оны эцэст ЗГ-аас нүүрсний биет хэмжээг 78 сая тоннд хүргэх зорилттой байгаа тул тээврийн салбарын өсөлт үргэлжилж, 2024 оны эцэст 7.1%-иар өсөх хүлээлттэй байна. Харин уул уурхайн салбарын өсөлт 2024 болон 2025 онд тус бүр 10.7% болон 4.8% байх хүлээлттэй байна.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАР

Үйлчилгээний салбар ДНБ-ийн 48.5%-ийг бүрдүүлдэг чухал салбар бөгөөд 2023 онд 14.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 9.9%-иар нэмэгдсэн байна. Энэхүү өсөлтөд тээврийн салбар 39.6%, худалдаа 6.8%, санхүү, даатгал 11.0%, мэдээлэл, холбоо 17.0%-иар өссөн нь голлон нөлөөлсөн бөгөөд уг салбарт худалдаа 35.2%, тээвэр 11.5%, санхүү, даатгал 9.8%, төрийн удирдлага 9.1%, ҮХХ 9.1%, боловсрол 7.8%, эрүүл мэнд 4.5%, мэдээлэл, холбоо 4.3%, бусад үйлчилгээний салбар 8.8%-ийг эзэлдэг.

Үйлчилгээний салбарын бодит ДНБ өсөлт %




*Төсөөлөл

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, Голомт банк

2024 оны эхний хагас жилд БДНБ 5.6%-иар өсөхөд үйлчилгээний салбар 4.4%-ийн эерэг нөлөө үзүүлсэн. 2023 оноос эхэлсэн эдийн засгийн идэвхжил иргэдийн хэрэглээг нэмэгдүүлэх замаар худалдаа, үйлчилгээний салбарт эерэг нөлөө бий болгож байна. Тодруулбал засгийн газрын зардал 2023 онд 22.5 их наяд төгрөгт хүрч зардлын дийлэнх хувь нь төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр болон нийгмийн халамж зэргээр зарцуулагдсан. Цаашлаад 2024 он гараад 4 сараас эхлэн төрийн албан хаагчдын цалинг 10-20%, дундаж тэтгэвэрийг 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн зэрэг нь иргэдийн орлого нэмэгдэхэд нөлөөлж өрхийн бодит орлого энэ оны эхний хагас жилд 17.3%-иар өссөн байна. Нөгөө талд нь өрхийн бодит зардал 15.3%-иар өсжээ. Иргэдийн худалдан авч буй бараа бүтээгдэхүүний зардал нь худалдаа, үйлчилгээний салбарын орлогыг нэмэгдүүлж, цаашлаад энэ салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн үйл ажиллагааг тэлж байна. Худалдаа үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН-ын тоо 2023 оны эцэст 37,122 болж өмнөх оноос 4.4%-иар өссөн бөгөөд улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийт ААН-ын 38.3%-ийг бүрдүүлж байна.

Худалдааны салбарын борлуулалтын орлогын өсөлт, ҮоҮ




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Худалдааны салбарын борлуулалтын орлого 2023 онд 65 их наяд төгрөг хүрч өмнөх оны мөн үеэс 23.8%-иар өссөн байна. Энэ тоог 2019 онтой харьцуулахад 2.2 дахин өсжээ. Харин энэ оны эхний хагас жилийн байдлаар нийт борлуулалт 31.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 16.7%-иар өссөн байна.

Зочид буудлын салбарын орлого 2023 оны эцэст 527 тэрбум болж өмнөх оны мөн үеэс 38%-иар өсжээ.


Зочид буудлын салбарын үзүүлэлт



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

2024 оны эхний хагас жилд зочид буудлын салбарын орлого 244 тэрбум төгрөг хүрч өмнөх оны мөн үеэс 12%-иар өссөн байна. Үүнд 3, түүнээс дээш одтой буудлын орлого 14.9 (9.3%) тэрбум төгрөг, зэрэглэлгүй зочид буудал болон амралтын газрынх 10.6 (19.5%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийтийн хоолны салбарын үзүүлэлт



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

2023 онд нийтийн хоолны салбарын орлого 1.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 18%-иар өссөн бол 2024 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 20.1%-иар өсөж 816 тэрбум төгрөг болжээ. Үүнд рестораны орлого өмнөх оны мөн үеэс 81.0 (21.0%) тэрбум төгрөг, кафе 13.9 (24.7%) тэрбум төгрөг, цайны газар 11.6 (16.6%) тэрбум төгрөг, катеринг 27.5 (19.0%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

2023 онд аж үйлдвэрийн салбар ДНБ-ийн 39%-ийг бүрдүүлж байна. Цаашлаад манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа нийт ААНБ-ын 8.6% нь, нийт ажиллагсдын 17.1% нь аж үйлдвэрийн салбарт ажилладаг.

2023 онд боловсруулах салбарын өсөлт 5.1%, цахилгаан, хий, агааржуулалтын салбарын өсөлт 5.0%, барилгын салбарын өсөлт 3.1%-иар өссөн байна.

Үйлдвэрлэлийн салбарын БДНБ өсөлт %



*Төсөөлөл

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, Голомт банк

Барилгын салбар нь манай улсын ДНБ-ийн 3.6%-ийг бүрдүүлдэг бөгөөд барилгын салбарын нэмэгдэл өртөг оны үнээр 2.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 304 тэрбум төгрөгөөр өссөн байна. Барилгын салбарт 8.1 мянган ААНБ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд төрөөс хэрэгжүүлж байгаа ипотекийн зээлүүд болон орон сууцны үнэ тогтворжуулах хөтөлбөрүүдтэй холбоотойгоор тус салбарт үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын тоо тасралтгүй өссөөр байна. Харин 2023 онд хийгдсэн нийт хөрөнгө оруулалтын 1.2 их наяд төгрөг буюу 5% нь барилгын салбарт хийгджээ. Энэхүү тоо өмнөх онтой харьцуулахад 15.9%-иар буюу 230.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл 2023 онд 7.5 их наяд төгрөгт хүрч, үүний 40.2%-ийг орон сууцны барилга, 33.8%-ийг орон сууцны бус барилга, 22.3%-ийг инженерийн барилга байгууламж, 3.8%-ийг их засварын ажил тус тус эзэлж байна.


Улсын хэмжээнд 2023 онд 19.2 мянган айл бүхий орон сууцны барилга, 711.0 км урт авто зам, 21.3 мянган суудал бүхий сургууль, соёлын барилга, 1211 ор бүхий эмнэлгийн барилга тус тус баригдаж ашиглалтад оруулсан байна.

2013 оноос төрөөс хэрэгжүүлж эхэлсэн ипотекийн жилийн 8 хувийн хүүтэй орон сууцны зээл нь иргэдэд үр өгөөжөө өгч, зээл олгож эхэлсэн. 2023 онд нийт 114.8 мянган иргэн хамрагдаж, өөрийн эзэмшлийн орон сууцтай болсон байна. Барилга угсралтын ажил эрчимтэй өрнөж байгаагийн дийлэнх нь нийслэл Улаанбаатар хотод явагдаж байгаа бөгөөд үүнийг даган энгийн орон сууцаас гадна чинээлэг хэрэглэгчдэд зориулсан, тэдний хэрэгцээ шаардлагыг хангах тансаг зэрэглэлийн орон сууцууд олноор баригдаж байна. Мөн орон сууцны бус барилга, ялангуяа худалдаа, үйлчилгээний барилга угсралтын ажил эрчимтэй нэмэгдэж байна.

Барилгын салбарт нөлөөлөх эдийн засгийн нөлөөлөл нь төсвийн хөрөнгө оруулалт, томоохон бүтээн байгуулалт, орон сууцны эрэлтийн түвшингээр тодорхойлогддог. 2024 оны улсын их хурлын сонгуулиар 3 намын хамтарсан Засгийн газар байгуулагдаж ирэх 4 жилийн хугацаанд хийх үйл ажиллагааны хөтөлбөрийг 2024 оны 8 сард УИХ-аар батлуулсан билээ. Хамтарсан засгийн газар ирэх 4 жилд 120 их наяд төгрөгийн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргасан ба үүний 12.3%-ийг улсын төсвөөр санхүүжүүлэх боломжтой талаар мэдэгдсэн. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт онцлох 15 мега төсөл байгаа бөгөөд тус бүр эдийн засгийн бүх салбаруудад эерэгээр нөлөөлөхүйц ач холбогдол бүхий төслүүд бөгөөд хэрвээ амжилттай хэрэгжвэл эдийн засагт маш том ахиц дэвшил гарах юм.

4

ЭДИЙН ЗАСГИЙН ИРЭЭДҮЙН ТААМАГЛАЛ



ИРЭЭДҮЙН ТААМАГЛАЛ

Олон улсын эдийн засгийн суурь урьдчилсан таамаглалыг дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ, бодлогын хүүний түвшин, мөн хөгжингүй орнуудын төсвийн бодлогод тулгуурлан гаргадаг. Олон улсын худалдаа 2023 оны зогсонги байдалтай харьцуулахад 2024-2025 оны хооронд дэлхийн эдийн засгийн өсөлтийг даган 3 орчим хувийн өсөлт үзүүлэх хүлээлттэй байна. Хил дамнасан худалдааны олон талын хязгаарлалтууд нэмэгдэж, сонгууль, геополитикийн суурь эрсдэлээс шалтгаалж олон улсын худалдаанд сөрөг нөлөө үүсэх эрсдэл байгаа ч олон улсын байгууллагуудаас худалдаа, ДНБ-ий харьцаа ирэх жилүүдэд тогтворжино гэсэн хүлээлттэй байна.

БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2024 онд 4.6 хувь харин 2025 онд 4.1 – 4.5 хувь болж буурах төлөвтэй байгаа юм. Хятад улс эдийн засгаа идэвхжүүлэх, үл хөдлөх хөрөнгийн салбарын уналтын нөлөөг бууруулах зорилгоор 139 тэрбум ам.долларын бонд гаргаж, инфляцын зорилтот түвшнийг 3 хувьд барихаар зорьж байна. Манай улстай хийх гадаад худалдааны эргэлт ирэх жилүүдэд тогтвортой байх ба нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр зэрэг гол түүхий эдийн эрэлт ирээдүйд өсөлттэй хэвээр байна. 2025 онд манай улсын нүүрсний экспортын биет хэмжээ 83 сая тонн байхаар төлөвлөгдсөн ба 2023 оны түүхэн дээд хэмжээг 17 сая тонноор нэмэгдүүлсэн үзүүлэлт юм. Цаашлаад 2025 оноос сэргээгдэх эрчим хүчний эрэлт хэрэгцээ ихээр нэмэгдэж байгаа тул манай улсын зэсийн экспортын хэмжээ нэмэгдэнэ.


ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2024 онд 2.9 хувь, 2025 онд 1.4 хувь болж буурах хүлээлттэй байна. Оросын түлш шатахууны зах зээлд АИ-95 төрлийн бензиний хомсдол үүсэж эхэлсэн ба Украины талаас Оросын газрын тос боловсруулах үйлдвэрүүд рүү удаа дараа довтолж, үйл ажиллагааг доголдуулж байгаатай холбоотой. Энэ оны 6-р сард нийт газрын тос боловсруулах хүчин чадлын 15.5 хувь нь ажиллаагүй зогссон гэдгийг Ройтерсийн судалгаанаас мэдээлсэн. Энэхүү эрсдэл нь ОХУ шатахууны экспортдоо хориг тавих эрсдэлийг бий болгож байгаа ба хориг тавьснаар манай улсын шатахууны үнэ өсөж, инфляцыг хөөрөгдөх шалтгаан болно.

АНУ-ын эдийн засгийн өсөлт 2024 онд 2.7 хувь, 2025 онд 1.9 хувь болж тогтворжих хандлагатай байна. 2024 оны 8 сард инфляцын түвшин 2.6 хувьд хүрч буурсан тул ХНС бодлогын хүүгээ 50 суурь нэгжээр бууруулж, 4.75-5 хувьд хүргэх шийдвэрийг гаргалаа. Иймээс ХНС бодлогын хүүгээ 50 суурь нэгжээр бууруулж, 4.75-5 хувьд хүргэх шийдвэр гаргасан.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН ТААМАГЛАЛ

Олон улсын болон дотоодын байгууллагуудаас Монгол улсын эдийн засгийн өсөлтийг энэ онд дунджаар 5 хувьд хүрнэ гэсэн таамаглалтай байна. 2024 оны эхний хагас жилд төсвийн зардлын тэлэлтээс үүдэлтэй цалин тэтгэврийн өсөлт нь өрхийн хэрэглээг нэмэгдүүлж эдийн засгийн идэвхжилд голлон нөлөөллөө.

Эдийн засгийн өсөлтийн дундаж таамаглал



	Шинэчилсэн	2024	2025
Голомт банк	2024 5-р сар	5.5%	5.0%
Монголбанк	2024 6-р сар	4.0%	6.5%
ОУВС	2024 4-р сар	6.5%	6.0%
ДБ	2024 6-р сар	4.8%	6.6%
АХБ	2024 4-р сар	4.1%	6.0%
Дундаж		5.0%	6.0%

Эх сурвалж: Монголбанк, ОУВС, Дэлхийн банк, АХБ, Голомт банк

2024 оны УИХ-ын сонгуулиар 3 намын хамтарсан Засгийн газар байгуулагдаж, ирэх 4 жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг УИХ-аар батлуулаад байна. Мөн 2024 оны төсвийн тодотгол хийгдэж улсын төсвийн зардлыг 2023 оны гүйцэтгэлээс даруй 7.9 их наяд төгрөгөөр нэмэгдүүлж баталлаа. Энэ оны 8 сарын байдлаар төсвийн зардал 17.3 их наяд төгрөг байгаа нь энэ жилийн хүлээгдэж буй төсвийн зардлын 57%-тай тэнцэж байна. Он дуустал төсвийн зардал нэмэгдэх мөн ирэх онд хийгдэх томоохон төсөл хөтөлбөрүүдийн бэлтгэл ажлууд хийгдэхээр байна. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт онцлох хэд хэдэн мега төслүүд байгаа бөгөөд нийт төслийн шаардлагатай санхүүжилтийн хэмжээг урьдчилсан байдлаар 120 их наяд төгрөг гэж тооцоолжээ. Харин уг санхүүжилтийн 12.3%-ийг улсын төсвөөр санхүүжүүлэх боломжтой гэж мэдэгдсэн. Мега төслүүд нь эдийн засгийн бүх салбаруудад эергээр нөлөөлөхүйц ач холбогдол бүхий төслүүд бөгөөд хэрвээ амжилттай хэрэгжвэл эдийн засагт маш том ахиц дэвшил гарахаар байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт багтсан мега төслүүд

№	Мега төслүүд	Төслийн тухай
1	Төмөр замын хилийн холболтууд	Экспортын хүчин чадал 40 сая.тн хүртэл нэмэгдэнэ. (Гашуунсухайт-Ганцмод 20 сая.тн, Ханги-Мандал 10 сая.тн, Шивээхүрэн-Сэхээ 10 сая.тн) -Экспортын орлого 2 дахин, төмөр замаар нүүрс экспортлох хүчин чадал 3 дахин, зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадал 2 дахин нэмэгдэж, тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэх, зорчигчид ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдэнэ.
2	Тавантолгойн 450 МВт-ын дулааны цахилгаан станц	Жилд 3,150.0 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, Оюутолгойн өсөн нэмэгдэх 2,242.5 сая кВт.ц хэрэглээ болон Тавантолгойн орд газрууд, бусад стратегийн ач холбогдолтой өмнөд бүсийн уул уурхайн төслийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг дотоодоос хангах боломж бүрдэнэ. Оюутолгой ХХК-ийн БНХАУ-аас импортолж байгаа 110-120 сая ам.долларын валютын урсгалыг зогсооно. Барилга угсралтын явцад давхардсан тоогоор 2000, ашиглалтад орсноор 300 байнгын ажлын байр шинээр бий болно.
3	Эгийн голын 310 МВт-ын усан цахилгаан станц	Эрчим хүчний системийн найдвартай, тогтвортой, шуурхай ажиллагааг хангаж, системийн эх үүсвэрийн зохистой харьцааг бүрдүүлнэ. ОХУ-д жил бүр төлдөг 25 сая ам.долларын импортын төлбөрийг хэмнэнэ. Түүхий нүүрсний хэрэглээг жил бүр 438,7 мянган тоннор, хүлэмжийн хийн ялгаруулалтыг 709 мянган тоннор бууруулна. 5.7 тэрбум шоо метр цэвэр усны нөөц бүрдүүлж, Монгол Улсын усан хангамжийн аюулгүй байдлыг хангана.
4	Сэргээгдэх эрчим хүч ба тархмал эх үүсвэр	Монгол Улс нь судалгаагаар 2,600 гВт сэргээгдэх эрчим хүчний нөөцтэй болох нь тогтоогдсон бөгөөд шинээр эх үүсвэрүүдийг бий болгох замаар өсөн нэмэгдэж буй дотоодын цахилгаан эрчим хүчний дутагдлыг нөхөх, бусад улс руу экспортлох боломжтой. Сэргээгдэх эрчим хүчний салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулснаар уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх боломж бүрдэхээс гадна хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, нүүрс хүчлийн хийн (carbon credit) арилжаанд оролцож, нэмэлт орлого олох боломж нээгдэнэ.
5	Хэрлэн-Тооно, Орхон-Онги ус дамжуулах шугам	Хэрлэн-Тооно усан цогцолбор: Хэрлэн голын олон жилийн дундаж урсцын 5-9%-ийг битүү хоолойгоор дамжуулан Хэнтий, Чойр, Дорноговь, Өмнөговь аймгийн хүн ам, мал аж ахуй, үйлдвэр, уул уурхайн усны хэрэгцээг бүрэн хангана. Жилдээ 30 мян. тн хүлэмжийн хийг бууруулна. "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд усны асуудлыг шийдвэрлэж, цөлжилт, хуурайшилтыг сааруулна. Орхон-Онги усан цогцолбор: Онги гол болон Улаан нуурыг сэргээж, усны төвшин тогтворжиж, нийгмийн хувьд Онги голын дагууд оршин сууж буй 29.2 мянган хүн ам, 230 гаруй мянган толгой мал сүргийг гадаргын усаар хангах нөхцөл бүрдэнэ. Агаар, хөрсний чийгшил, газрын доорх усны тэжээгдэл нэмэгдэж, нуурын орчны бүсийн экосистем, биологийн олон янз байдал сэргэж, хөрсний элэгдэл эвдрэлд орох нөхцөл багасаж, цөлжилтийг бууруулна.
6	Монгол, Францын хамтарсан уран, атомын цахилгаан станц	Үйлдвэрлэл бүрэн хүчин чадлаараа ажиллавал жилд 2,500 тонн ураныг олборлож экспортолно. Төсөл хэрэгжих хугацаанд улс, орон нутгийн төсөвт нэг тэрбум гаруй ам.долларын татвар төлөх тооцоотой. Үйлдвэрлэлийн туршилтын төсөл дээр үндсэн үйлдвэрлэлийн олборлолт эхлэхэд 1,000 гаруй ажлын байр бий болно. Улс, орон нутгийн хэмжээнд томоохон хэмжээний худалдан авалт хийж, бизнесийн боломж нэмэгдэнэ.
7	Нүүрс-хими, Кокс-химийн цогцолбор	Нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, боловсруулах үйлдвэрлэлийг нэг шат ахиулснаар экспортын орлогыг нэмэгдүүлэх, олон улсын түүхийн эдийн үнээс хараат байдлыг бууруулах боломж бүрдэнэ. Кокс-химийн үйлдвэр: Нүүрс баяжуулах үйлдвэрийн 1 дүгээр шатанд 10 сая тонн коксжих нүүрсийг угааж, 5.4 сая тонн баяжуулсан нүүрс, 3 сая тонн завсрын бүтээгдэхүүн (мидлинг) үйлдвэрлэнэ. 2.7 сая тонн баяжуулсан нүүрсийг боловсруулж, 2 сая тонн хатуу кокс, 107 МВт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэнэ. Дотоодын хэрэглээнээс илүү гарсан 1.5 сая тонн коксын бүтээгдэхүүнийг экспортолно. Алтанширээт УТП:140 га талбайд төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэр, нүүрс угаах үйлдвэр, коксын үйлдвэр, төмрийн хүдрийн хорголжийн гэх мэт дагалдах үйлдвэрүүд бүхий 500 мян.тн/жил ширэм үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр ашиглалтад орно.
8	Зэс боловсруулах цогцолбор	Жилд 560 мян.тн зэсийн баяжмал боловсруулж, 125 мян.тн катодын зэс, 72 кг алт, 38.2 тн мөнгөн гулдмай болон 182 мян.тн элементийн хүхэр үйлдвэрлэж, 1.1 тэрбум ам долларын борлуулалтын орлогыг бүрдүүлнэ. -Катодын зэсийн үйлдвэр нь дотоодын зэс утас, кабель, цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэх салбарыг хөгжүүлэхэд томоохон түлхэц үзүүлнэ. Үйлдвэрээс гарган авах 182 мянган тонн элементийн хүхэр нь химийн болон бордооны үйлдвэрлэлд өргөн ашиглагдах тул нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг нэмэгдүүлнэ.
9	Гангийн үйлдвэр	Дотоодын тасралтгүй нэмэгдэж буй ган арматур болон бусад ган бүтээгдэхүүний хэрэгцээг дотооддоо бүрэн хангах зорилтын хүрээнд 1.0 сая тонн ган бэлдэц, бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Гангийн үйлдвэрийг ашиглалтад оруулж эхний ээлжид 500 мян.тн ширэм, 500 мян.тн ган бэлдэц үйлдвэрлэж, ган бэлдцээс барилгын арматур, булан төмөр, төмөр утас зэрэг ган бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, дотоодын барилгын арматурын хэрэгцээг бүрэн хангана.
10	Оюу толгой төсөлд түшиглэсэн алт цэвэршүүлэх үйлдвэр	Жилд гадаад орны алт цэвэршүүлэх үйлдвэрт цэвэршүүлж, мөнгөжүүлдэг алтны 70 хувийг дотооддоо цэвэршүүлэх боломж бүрдэнэ. Баяжуулсан алтны хувийг нэмэгдүүлж, олон улсын зах зээлд борлуулж, валютын орлогыг нэмэгдүүлэх боломжтой. Монгол Улс алтаа одоог хүртэл гадаад орнуудад цэвэршүүлж байгаа бөгөөд үйлдвэр ашиглалтад орсноор үүнтэй холбогдон гарах тээвэр, даатгал, хамгаалалтын зардал хэмнэгдэнэ.

Эх сурвалж: Parliament

Жил бүрийн 11 сард дараа жилийн төсөв батлагддаг бөгөөд засгийн газраас 2025 оны төсвийн төслийг УИХ-д өргөн бариад байна. Үүнтэй холбоотойгоор ирэх онд хийгдэх дараах 15 дэд бүтцийн хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжих хугацаа, санхүүжилтийн хамт танилцууллаа. Эдгээр төслүүд нь голчлон авто зам, эрчим хүч, дэд бүтцийн чиглэлийн төсөл бөгөөд хэрэгжих хугацааны хувьд 2025 онд нийт төслийн 55.6% буюу 355 төсөл, 2026 онд 39.1% буюу 250 төсөл, 2027 онд 5.3% буюу 34 төсөл хэрэгжинэ гэж мэдэгдсэн байна.

Хөрөнгө оруулалт дэд бүтцийн төслүүд


№	Төслийн нэр	Төслийн тухай	Ашиглалтанд орох хугацаа	Шаардлагатай санхүүжилт (тэрбум.Төг)	Санхүүжилтын эх үүсвэр
1	Ган татлагат гүүр	6 эгнээ бүхий 4.7км авто зам, 900 метр гүүр, 80м нүхэн гарц	2028	2,831.4	ЗГ өрийн баталгаа
2	Хөшигийн хөндийн туннел	15.2 км бүхий 2 эгнээтэй хос туннел	2028	5,474.7	ЗГ өрийн баталгаа
3	Үндэсний хиймэл дагуул	2024 онд гэрээ байгуулж төслийг эхлэх, угсралт, үйлдвэрлэл 2026 он, сансарт хөөрөх 2027-2041, ашиглаж дуусах 2042	2027	760.6	Улсын төсөв, БНФУ-ын нэн хөнгөлөлттэй зээл
4	Эрдэнбүрэнгийн УЦС	90 Мвт хүчин чадалтай УЦС	2028	855.9	БНХАУ-н эксим банк
5	Газрын тос боловсруулах үйлдвэр	жилд 1.5 тонн түүхий тос боловсруулах	2027	4,178.8	БНЭУ-ын эксим банк
6	ЗГ-ын нэг цэгийн үйлчилгээний цогцолбор	Номтын ам, шинэ зуунмод хотод 70,000 метр квадрат бүхий ногоон барилга	2027	676.3	Улсын төсөв
7	Хөшигийн хөндий-шинэ зуунмод хот дэд бүтэц	80 мянган ажлын байр, 34 мянган хүн ам	2027	418.9	Улсын төсөв
8	УБ төв цэвэрлэх байгууламж	хоногт 250,000 м3 хүчин чадалтай	2026	843.8	БНХАУ-н эксим банк
9	Налайх тэрэлж авто замын өргөтгөл	37км 6 гүүр	2027	222	Улсын төсөв
10	УБ хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл	Ус гүн цэвэршүүлэх байгууламж, хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр	2026	1,183.3	АНУ мянганы сорилтын сан
11	Шинэ Хархорум Хот, төслийн судалгаа, ТЭЗҮ, Зураг	189,363 га бүхий 500 мянган хүн ам, бүтээн байгуулалт эхлэх хугацаа 2026	-	60.8	Улсын төсөв
12	Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц	-	2027	213.2	Улсын төсөв
13	Бүс нутгийн найдвартай цахилгаан хангамж 1-р үе шат	-	2027	59.9	Улсын төсөв
14	Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр	1-р үе шат	2027	90	Улсын төсөв
15	Боомтуудын шинэчлэл	Цагааннуур, Боршоо, Алтанбулаг, Хавирга, Бичигт, Замын-Үүд, Гашуунсухайт, Шивээхүрэн, Булган, Хөшигийн Хөндий боомт	2030	721.3	Улсын төсөв, АХБ

Эх сурвалж: Сангийн яам

2025 оны төсвийн бодлогод дээр дурдагдсан хөгжлийн том төслүүдийг эхлүүлэх, төрийн оролцоог багасгаж хувийн хэвшлийг дэмжихэд чиглэж байгаа бөгөөд ирэх жил хөгжлийн хөрөнгө оруулалт, бүсийн томоохон дэд бүтцийг санхүүжүүлэхэд 6.9 их наяд төгрөгийг зарцуулахаар болж байгаа нь түүхэнд хамгийн өндөр хөрөнгө оруулалтыг дэмжсэн жил болох төлөвтэй байна. Ирэх оны нийт хөрөнгө оруулалтын 24% нь зам тээврийн салбар, 10% нь дэд бүтэц, орон сууцжуулалт, 8% нь төрийн үйлчилгээ, 8% нь эрчим хүч, 9% нь боловсрол, 7% нь аж үйлдвэрийн салбар, бусад салбарын хөрөнгө оруулалт 35 хувийг эзэлж байна. Ийнхүү шинэ засгийн газрын бодлого төлөвлөлт нь суурь дэд бүтцийн асуудлыг шийдэж үйлдвэрлэл, худалдаа, ажил эрхлэлтийг нэмэгдүүлж эдийн засгаа тэтгэх зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Гэсэн хэдий ч ирэх жилийн төсвийн зардал 35.6 их наяд, харин орлого 33.7 их наяд төгрөг болж төсвийн тэнцэл 1.9 их наяд төгрөгийн алдагдалтай боловсруулагдсан нь ирэх жил төсвийн хэт тэлэлтээс шалтгаалж зах зээлд мөнгөний нийлүүлэлт өсөж инфляц, төлбөрийн тэнцэл, ханшид дарамт ирэх эрсдэлтэй байна.

ИНФЛЯЦЫН ТААМАГЛАЛ

Инфляцын дундаж таамаглал



Эх сурвалж: Монголбанк, ОУВС, Дэлхийн банк, АХБ, Голомт банк

Мөнгөний нийлүүлэлт энэ оны 8 сарын байдлаар 41 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 27.7%-иар өссөн. Нийт зээлийн үлдэгдэл эхний хагас жилийн байдлаар 6 их наядаар нэмэгдсэн нь эдийн засаг хэт халалтад орох, өрхийн өрийн дарамт үүсэх эрсдэл нэмэгдэж байна. Цаашлаад импорт оны эхнээс тасралтгүй өсөж 8 сарын байдлаар өмнөх мөн үеэс 26.1%-р өссөн байна. Ийнхүү иргэдийн цалин орлогын өсөлт нь хэрэглээг нэмэгдүүлж импортын бараа бүтээгдэхүүн болж гарах нь валютын гарах урсгалыг нэмэгдүүлж төлбөрийн тэнцэлд дарамт учруулах эрсдэлтэй. Төлбөрийн тэнцэл алдагдалтай байх нь гадаад валютын нөөцийг бууруулж ханш сулрах гол хүчин зүйл болно. Нөгөө талдаа иргэдийн худалдан авалт нэмэгдэж, эрэлт өсөх нь үнийн өсөлтийг өдөөх тул инфляц оны эцэст болон ирэх онуудад одоогийн түвшнээс өсөх хүлээлттэй байна. Дээрх байгууллагуудын дундаж төсөөллөөр инфляц оны эцэст 8.2% харин ирэх онд 8.0% байх хүлээлттэй байна.

Монгол банкнаас бодлогын хүүг энэ онд 3 удаа тус бүр 1 нэгж хувиар буулгаж 10% хүргэсэн нь инфляцын өсөлт хүлээгдэж байснаас бага байгаатай холбон тайлбарлаж байгаа бөгөөд 2025 онд барих мөнгөний бодлогын үндсэн чиглэлд инфляцын зорилтот интервалыг 5% (+-2%) болгон бууруулах төлөвлөгөөтэй байгаа талаар дурдсан. Цаашлаад манай улсын эдийн засагт ирэх жилүүдэд учирч болох томоохон эрсдэлүүд байгаа бөгөөд үүнд уур амьсгалын өөрчлөлт, төсвийн хэт тэлэлт, Орос Хятадтай холбоотой геополитикийн асуудлууд багтаж байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан зудын нөхцөл байдал ирэх жилүүдэд үргэлжилбэл түүнийг дагасан үйлдвэрлэлүүд агшиж малчдын амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлнэ. Үүний зэрэгцээ засгийн газрын шийдвэрийн дагуу ирэх жилүүдэд хийгдэх мега төслүүд хэрэгжихгүй байх, төсвийн зардлын хэт өсөлт нь инфляцын дарамтыг нэмэгдүүлж, төсвийн болон урсгал дансны алдагдлыг нэмэгдүүлэх эрсдэлийг бий болгож байна. Дэлхийн эдийн засгийн өсөлт сэргэж байгаа ч геополитикийн хурцадмал байдал нь эдийн засгийн цаашдын төлөвт тодорхой бус байдлыг нэмэгдүүлсээр байгааг олон улсын байгууллагууд анхааруулсаар байна.

НЭГТГЭЛ

Үзүүлэлт	Нэгж	Гүйцэтгэл			Таамаглал	
		2022	2023	2024 8-р сар	2024*	2025*
Бодит эдийн засаг (2024H1)						
Эдийн засгийн өсөлт1	%	4.8%	7.4%	5.6%	5.5%	5.0%
Уул уурхай	%	-15.3%	23.4%	15.4%	10.7%	4.8%
Тээвэр	%	9.2%	39.6%	24.7%	7.1%	2.1%
Барилга	%	8.2%	3.1%	19.5%	11.5%	4.9%
Боловсруулах	%	6.1%	5.0%	6.3%	3.3%	3.5%
Худалдаа	%	10.1%	6.7%	6.8%	7.1%	5.1%
Үйлчилгээ	%	5.4%	5.8%	7.1%	4.0%	4.9%
Мөнгөний зах зээл						
Инфляц	%	13.2%	7.9%	6.5%	8.1%	7.8%
Түүхий эдийн зах зээлийн үнэ						
Нүүрс2	\$/тонн	427.7	149.4	154.2	135.8	135.1
Зэс3	\$/тонн	8,371.1	8,407.9	8,981.1	8,550.7	8,661.2
Алт4	\$/трой унц	1,797.4	2,034.7	2,468.3	2,685.4	2,724.3

Тайлбар

- 1 Эдийн засгийн өсөлтийг тооцохдоо 2015 оны суурь бүхий бодит ДНБ-ий жилийн өсөлтийг авсан болно.
- 2 Австрийн эрчим хүчний нүүрс, FOB Newcastle/Port Kembla
- 3 А зэрэглэлийн катод, Лондоний металлын биржийн спот ханш
- 4 Лондоны үнэт металлын зах зээлийн холбооны 3PM-н ханш

Эх сурвалж

- Үндэсний статистикийн хороо
- Монголбанк
- Олон улсын валютын сан
- Эдийн засгийн судалгааны алба, Голомт банк

Байгууллагын банкны газар:

И-мэйл хаяг: corporatebanking@golomtbank.com
Корпорэйт лавлах утас: 7011-7676

Үйлдвэр худалдааны хэлтэс: 7575-1111 (1403)
Бизнес хамтын ажиллагааны хэлтэс: 7575-1111 (1200)
Уул уурхай, дэд бүтцийн хэлтэс: 7575-1111 (1185)

Байгууллага хөгжлийн газар:

И-мэйл хаяг: smedepartment@golomtbank.com
Корпорэйт лавлах утас: 7011-7676

Байгууллага харилцааны хэлтэс: 7575-1111 (1179)

Нөөцийн удирдлагын газар:

И-мэйл хаяг: forex@golomtbank.com, dealers@golomtbank.com

Арилжааны хэлтэс: 7555-3434

Эдийн засгийн судалгааны алба:

И-мэйл хаяг: eru@golomtbank.com
Утас: 7575-1111 (1277)

Хаяг: Голомт банкны Төв байр,
Д.Сүхбаатарын талбай 5, Ш/х-22,
Улаанбаатар 15160, Монгол улс

Swift: GLMTMNUB